

НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2024 оны 12 дугаар сарын 05-ны өдөр Улаанбаатар хот

Д/д	Стратеги болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая төгрөгөөр)	Шалтгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
Стратегийн төлөвлөгөөний зорилго 1: Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ болон эмнэлгийн тусламж үйлчилгээний зорилтот түвшинг бүрэн хангана.							
1.1	Өсвөр үе, залуусын дунд хар тамхи, мансууруулах бодис, бусад хорт зуршлаас сэргийлэх, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулна.	50.0 улсын төсөв	Зохион байгуулсан арга хэмжээ, тоо	3	4	Өсвөр үе, залуусын дунд хар тамхи, мансууруулах бодис, бусад хорт зуршлаас сэргийлэх чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүлнээ. 1.Дэлхийн тамхигүй өдрийн хүрээнд тамхины хор уршиг, электрон тамхины гэж нөлөө сэдвээр хүүхэд өсвөр үеийхэнд зориулсан 4 төрлийн постер бэлтгэн цахим хуудсаар дамжуулан хүргэсэн. 2.Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жилийн нээлт Жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит талбайд болж мансууруулах бодис, донтолт, архи тамхины хэрэглээ, хор уршиг сэдвээр тусгай асарыг ХУД-ийн эрүүл мэндийн төв ажиллуулж 75 хүнд тусгайлан ганцаарчилсан зөвлөгөө өгч 450 гаруй хүнд сурталчилгааны материал түгээсэн. 3.Тамхинаас татгалзъя, тамхины хор уршиг, тамхины шалтгаант зурх судасны өвчин, уушгины замын өвчин, тамхи спортод зохицохгүй, дам тамхидалтад өртөлт, дотоод орчны агаар бохирдол, электрон тамхины хор нөлөө гэх агуулга бүхий 8 төрлийн видео шторжийг бэлтгэж, байгууллагын цахим хуудас болон харьяалах эрүүл мэндийн байгууллагуудын цахим хуудсаар түгээж ажилласан. Байгууллагын цахим хуудаснаас 89159 хүнд хүрсэн байна. 4. Электрон тамхи, дэлгэцийн донтолт, сэтгэцийн эрүүл мэнд, мансууруулах бодис түүний хор уршлаас сэргийлэх нь чиглэлээр дүүргийн цагдаагийн хэлтэс, ЕБС-ын нийгмийн ажилтнууд, ерхийн эрүүл мэндийн төвийн нийгмийн ажилтнуудтай хамтран 154 ерөнхий боловсролын сурагчдад тус тус эрүүл мэндийн боловсрол олгосон. 5.Оюутны эрүүл мэндийг дэмжих сарын аяны хүрээнд оюутан залууст мөн хар тамхи мансууруулах эм, бодис, архи,	100

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая төгрөгөөр)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	8
1.2	Хүн амын эрүүл мэндийн байдал, эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгоно.	150.0 нийслэл ийн төсөв	Зохион байгуулсан арга хэмжээ, тоо	7	8	Утаат болон электрон тамхины хор уршгийг талгаар нийт 2711 оюутанд сургалт зохион байгуулж сургалтын гарын авлага материал түгээсэн байна. Хүн амын эрүүл мэндийн байдал, эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр дараах арга хэмжээнүүдийг зохион байгуулсан. Үүнд: 1.Хэрэхийн шалтгаант зүрхний өвчлөгөөс урьдчилан сэргийлэх, бууруулах төслийн хүрээнд Улаанбаатар хотын 9 дүүргийн ЕБС-ийн 6-15 настай 37000 гаруй сурагчдыг “Стрелтококийн халдвар илрүүлэх үзлэг шинжилгээ”-нд хамруулсан. 2.“Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай” хуулийг баталж, 2024 оны 5 дугаар сарын 22-ны өдөр харьяа 6 дүүргийн эрүүл мэндийн төв, ШУд эрүү нүүрний төв Жанжин Д.Сүхбаатарын талбайд иргэдэд нөхөн үржихүй эрүүл мэнд, эрүүл амьдралын хэв маяг, зөв зохистой хооллолт, идэвхтэй дасгал хөдөлгөөн, зүрх судасны өвчлөл, чихрийн шижин, архи тамхины эсрэг, ДОХ, элэгний В, С вирусын халдварын илрүүлэг, амны хөндийн үзлэг оношилгоо хийж, нийт 2310 хүнд зөвлөгөө мэдээлэл хүргэсэн. 3.“Эрүүл монгол хүн” үндэсний хөдөлгөөний 2024 оны үйл ажиллагааны хүрээнд 5 төрлийн видео шторк, 6 төрлийн зурагт хуудас боловсруулж, нийслэл дэх 7 сурталчилгааны дэлгэцээр 7-21 хоног түгээж, 7 төрлийн зурагт хуудсыг хэвлэж, нийслэл дэх 22 автобусны зогсоол, 15 тудамжны мэдээллийн байгууламж дээр байршуулан иргэдэд хүргэсэн. Видео шторкуудийг 133 албан байгууллага, нийтийн орон сууц, хотхоны нийт 1025 зар сурталчилгааны дэлгэцээр түгээсэн. 4.Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран “Ногоон технологи-2024” өдөрлөгийг 2024 оны 09 дүгээр сарын 18, 19-ний өдрүүдэд Жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион	100

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая төгрөгөөр)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	8
						байгуулж, иргэд, олон нийтэд анхны тусламж үзүүлэх сургалт, танилцуулга хийж 250 хүнд хүргэсэн. 1."Автомашингүй өдөр-2024" арга хэмжээг зохион байгуулж, эрүүл мэндийн үзлэгт давхардсан тоогоор 5159 хүнийг хамруулсан. Автомашингүй өдрийн ач холбогдлыг таниулах, иргэдийг уриалсан 30 секундийн 1 видео контентыг бэлтгэн нийслэлийн Эрүүл мэндийн газар, Тээврийн цагдаагийн алба болон бусад байгууллагын цахим хуудас, олон нийтийн сүлжээгээр түгээж, иргэдэд хүргэсэн. 2. Эрүүл мэндийн газрын эрхэлсэн цахим сүлжээний хаягаар тэмдэглэлт баяр, наадмын үеэр болон улирлын чанартай гарах эрүүл мэндийн эрсдэлтэй зан үйл, осол тэмтлээс сэргийлэх, эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр сэрэмжлүүлэг бүхий 72 төрлийн зурагт хуудас болон, видео шторжкоор 668,257 хүнд эрүүл мэндийн мэдээлэл, сурталчилгаа хийсэн. 3. Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/859 дүгээр захирамжийг батлуулж, өсвөр үе, залуучуудын нөхөн үржихүйн эрүүл мэнд, хүсээгүй жирэмслэлт, бэлгийн эрүүл мэндийн боловсрол олж авах ач холбогдол, мэдлэг хандлагыг дээшлүүлэх 2 төрлийн видео шторжийг хийж UBS төлөвзийн оргил цагаар 20 хоног нэвтрүүлж, байгууллагын болон харьяа эрүүл мэндийн төвүүдийн цахим хаягаар эрчимжүүлэн түгээж 650,000 хүнд хүргэсэн. 4. 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн байдлаар урьдчилан сэргийлэх үзлэг, эрт илрүүлэлт 869418 иргэн хамрагдсан. Эрт илрүүлэлт хамрагдахаар ирж буй иргэдэд зориулж бэлтгэл хэрхэн хангах, эрт илрүүлэлт хамрагдахаар ирэхийн өмнө хийх бэлтгэл, анхаарах асуудал, багцийн үзлэг шинжилгээнд хамруулж буй шинжилгээний мэдээллүүдийг багтаасан цуврал постер боловсруулан иргэдэд хүргэсэн.	
1.3	Товлолт болон товлолт бус дархлаажуулалтын хамрагдалтыг	-	Товлолт болон товлолт бус	96	96	Товлолт дархлаажуулалтын хамралтын мэдээг сар бүр тогтмол ХӨСҮТ-д хүргүүлэн ажиллаж байна. 2024 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар: Нийт 8 төрлийн товлолт	99

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая төгрөгөөр)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлтийн хувь
1	2 нэмэгдүүлэх замаар тарилгаар сэргийлэгддэг халдварт өвчний тандаглыг бэхжүүлэх.	3	4 дархлаажуулалтад хамрагдалт, хувь	5	6	7 вакцины 19 түнгийн дархлаажуулалтын хамралтын дундаж хувь 95.3% байна. Үүнд: 1.БЦЖ (1 түн) – 99.4% 2.Гепатит В (1 түн) – 99.5% 3.Саа (4 түн) – 95.8% 4.Тавт (3 түн) – 96.2% 5.УГУ (2 түн) – 95.5% 6.Гепатит А (2 түн) – 93.9% 7.Пневмококк (3 түн) – 96.5% 8.Сахуу-татран (2 түн) – 93%.	8
						Монгол Улсад Улаанбурхан өвчний тохиолдол бүртгэгдсэнтэй холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2015 оны "Дархлаажуулалтын тухай" А/261 дүгээр тушаал, 2018 оны "Халдварт өвчний тохиолдлыг тандах журам батлах тухай" А/527 дугаар тушаал, 2024 оны "Улаанбурхан өвчний тархалтаас сэргийлэх, зарим арга хэмжээний тухай" 03 дугаар албан даалгавар, "Улаанбурхан өвчний дэгдэлтийн үеийн дархлаажуулалтыг зохион байгуулах тухай" А/344 дүгээр тушаал, Нийслэлийн Эрүүл мэндийн тазрын даргын 2024 оны "Цуурхай удирдлагын баг томилох тухай" А/115 дугаар тушаалын хэрэгжилтийг ханган ажиллаж зорилтот бүлгийн нийт хамрагдвал зохих 33739 хүнээс 32194 буюу 95%-ийг Улаанбурхан өвчний эсрэг /УГУ, УУ/ вакцинаар нэмэлт болон нөхөн дархлаажуулалтад хамруулсан. Улаанбурхан өвчний тархалтаас сэргийлэх зорилгоор нийслэлийн өрхийн эрүүл мэндийн төвүүдийн дунд НЭМТ-ын даргын "Улаанбурхан өвчний халдвараас сэргийлэх аян зохион байгуулах тухай" А/121 дүгээр тушаалаар аян зохион байгуулан, явцын хяналт тавьж, дэмжлэгт хяналтыг хийж ажиллалаа. Тус аяныг дүгнэх арга хэмжээг 2 үе шаттай зохион байгуулж нийслэлийн 149 өрхийн эрүүл мэндийн төвөөс үйл ажиллагаагаараа тэргүүлсэн 3 ӨЗМТ-ийг автомашин, 6 ӨЗМТ-ийг компьютер принтерээр шагнаж урамшуулсан.	

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая төгрөгөөр)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	8
1.4	Бага насны хүүхдийн суурь өвчлөл хоол тэжээлийн цочмог дутлыг илрүүлэн, эрүүлжүүлэх, урьдчилан сэргийлэх замаар эндэгдлийг бууруулна.	-	Өсөлт хөгжлийн хяналтад хамрагдсан хүүхдийн түвшин, хувь	92	93	2024 оны эхний 11 сарын байдлаар 9 дүүргийн эрүүл мэндийн төв, 4 нэгдсэн эмнэлэг, 3 хүүхдийн сэргээн засах төв, өрхийн эрүүл мэндийн төв, тосгоны эрүүл мэндийн төвүүдээр дамжуулан 5 хүртэлх насны 172708 хүүхдийг давахардсан байдлаар 775275 удаа өсөлт хөгжлийн хяналтад хамруулсан нь насны товлолоор өсөлт хөгжлийн хяналтын хамрагдалт 96%-ийн үзүүлэлттэй байна.	100
1.5	“Эхээс уралт дамжих турвалсан халдвар”-ыг бууруулах, ургийн гэжиг эрт илрүүлэх боломжийг бүрдүүлж, жирэмсний эрт хяналтыг нэмэгдүүлнэ.	-	Жирэмсэн эмэгтэйчүүд ийн жирэмсний эхний 3 сарын хяналтад орсон эмэгтэйчүүд , хувь	91.4	93	Эх хүүхдийн эрүүл мэндийн үзүүлэлтэд дүн шинжилгээ хийн ажиглаж байна. НЭМГ-ын даргын 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн Эх хүүхдэд үзүүлэх тусламж, үйлчилгээг сайжруулах тухай 01/309 дугаар албан бичгийг Харьяа Эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлж, жирэмсэн эхийн эрсдэлээр үнэлэх талаар арга зүйг цахимаар өгч, 220 цэгээс 400 эмч оролцсон.	100
			Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэлийн түвшин, промилль	15.7	14.9	2024 оны эхний 11 сарын байдлаар 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1000 амьд төрөлтөд 14.4 буюу өмнөх оны мөн үеэс 0.8 промиллиор буусан үзүүлэлттэй байна.	100

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая төгрөгөөр)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлгийн хувь
1	2	3	4	5	6	7	8
			Эхээс урагт дамжих халдвар илрүүлэх тоног төхөөрөмж /ТОРСН/, тоо	2	2	Баянзүрх, Баянгол, Налайх, Сонгинохайрхан, Хан-Уул, Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн төв буюу нийслэлийн 6 дүүргийн эрүүл мэндийн төв нь эхээс урагт дамжих халдвар илрүүлэх ТОРСН шинжилгээ хийх иммунологийн Maglumi 800 аппаратаар бүрэн хангагдсан. 2024 оны эхний 10 сарын байдлаар нийт 1044 сорьцонд шинжилгээ хийгээд байна.	100
			Ургийн гажиг илрүүлэх 4Д ЭХО, тоо	5	3	Баянгол, Сонгинохайрхан, Багануур, Сүхбаатар, Хан-Уул дүүргийн эрүүл мэндийн төв, Сонгинохайрхан, Сүхбаатар нэгдсэн эмнэлэг, Хүрээ амаржих газар 4Д ЭХО аппаратаар бүрэн хангагдаж, 2024 оны эхний 10 сарын байдлаар жирэмсний 5 сартай 5672 жирэмсэн эмэгтэйд оношилгоо хийж 110 ургийн гажиг илрүүлээд байна.	100
1.6	Амаржих газруудын үйл ажиллагааг хэвийн явуулахад мэргэжил, арга зүйтээр хангаж ажиллана.	-	Хамрагдсан байгууллагын тоо	-	3	Монгол Улсын Засгийн газрын 2023 оны "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх зарим байгууллагын талаар авах арга хэмжээний тухай" 460 дугаар тогтоолын дагуу Нийслэлийн хүн амд эх барих, нярай, эмэгтэйчүүдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж буй "Өргөө", "Хүрээ", "Амгалан" амаржих газрууд нийслэлийн харьяанд 2023 оны 12 дугаар сард шилжин ирсэн. Салбар хоорондын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх чиглэлээр олон ажил гүйцэтгэж байна. Тухайлбал: - НЗД-аар ажлуулсан "Нийслэлийн эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн орон тооны бүс салбар зөвлөл"-ийн үйл ажиллагааг тогтмолжуулсан.	100

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая төгрөгөөр)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	8
						- Эрүүл мэндийн салбарт 2021 оноос санхүүжилтийн цогц шинэчлэлийг хэрэгжүүлэн гүйцэтгэлээр санхүүжүүлж байгаагаар холбоотой амаржих газруудад эмийн өр төлбөр үүссэн. Энэхүү асуудлыг Нийслэлийн Засаг даргад уламжлан ЭМ-ийн сайдад 2024.08.23-ны 01/4790 дугаар албан бичгээр холбогдох хууль тогтоомжийн хүрээнд жирэмсэн, төрөлт, төрсний дараах эх барихын болон нярайд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээг улсын төсвөөр, эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээг гүйцэтгэлээр санхүүжүүлэх боломжийн талаар санал хүргүүлсэн. - НЭМГ-ын даргын 2024 оны А/29 дүгээр тушаалаар "Өргөө" амаржих газарт ЗЭХХЗГ, НЭМГ, НДАА, НАГ-ын удирдлагуудтай зөвшилцөж, хамтарсан менежментийг баг томилж ажилласан. Урьдчилсан дүгнэлтийг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. - НЭМГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу томилогдсон ажлын хэсгийн бүрэлдэхүүн Өргөө, Хүрээ, Амгалан амаржих газрын эх барих, эмэгтэйчүүдийн тусламж, үйлчилгээ, сувиллахуй, дархлаажуулалт, халдварын сэргийлэлт, хяналт, чанар, аюулгүй байдлын өнөөгийн байдалтай танилцаж, үйлчлүүлэгчээс сэтгэл ханамжийн судалгаа авч, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн. - Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар "Хүрээ" амаржих газар 9 давхар 8000 кв.м барилга ашиглалтад орсон. Шаардлагатай тоног төхөөрөмжийн 6.5 тэрбум төгрөгийг нийслэлийн төсвийн тодотголд багтуулж, НХААГ-аас тэндэр зарлагдан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. - Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 3 амаржих газарт нэг нэг гемодиализийн аппарат, Өргөө амаржих газарт нарийн тархи болон бүтэн биеийг хөргөөх, дутуу төрсөн 250 граммаас дээш жинтэй нарийн амьсгалыг удирдах, нарийн шарлалт ихтэй үед нарайг бүх талаас нь 4 цагийн дотор шарх /360/ аппаратуудад шаардлагатай 869 сая төгрөгийг тодотголоор багтуулсан.	

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая төгрөгөөр)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлгийн хувь
1	2	3	4	5	6	7	8
			Оношлогдсон нийт өвчтөнөөс хяналтад хамруулсан өвчтөний хувь	100	100	Эпидений хорт хавдрын үзлэгт хамрагдсан хүн амын тоо 106742, үүнээс хавдар оношлогдсон 50 тохиолдол байна. Халдварт бус өвчний эрт илрүүлгээр артерийн даралт ихсэх өвчин оношлогдсон 3211, чихрийн шижин өвчин оношлогдсон 1121 тохиолдол, умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлгээс Пап зэрэг буюу эсийн түвшинд өөрчлөлттэй илэрсэн 320 эмэгтэйт тус тус хяналтад аваад байна. /4774/ Нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд нөхөн үржихүйн насны 414364, үүнээс 58026 зорилтот бүлгийн эмэгтэйчүүд байна. 2024 оны 11 сарын байдлаар жирэмснээс сэргийлэх арга хэрэгсэлээр зорилтот бүлгийн 40175 эмэгтэй хангагдаж, хамрагдалт 69.2%-д хүрсэн. Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/859 дүгээр захирамжийг батлуулж, өсвөр үе, залуучуудын нөхөн үржихүйн эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлт, хүсээгүй жирэмслэлт, бэлгийн эрүүл мэндийн боловсрол олж авах ач холбогдол, мэдлэг хандлагыг дээшлүүлэх 2 видео шторжийг хийж, түгээн 550,000 хүнд хүргэсэн. "Оюутны эрүүл мэндийг дэмжих сарын аян"-ы хүрээнд 42 их дээд сургууль, мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвд нөхөн үржихүй, гэр бүл төлөвлөлт сэдвүүдийн хүрээнд 31 удаагийн сургалт хийж, 2615 оюутан залуусыг хамруулсан. 2024 оны эхний 10 сарын байдлаар халдварт өвчний 16272 тохиолдол бүртгэгдэж, 10000 хүн амд 100.4 байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1673 тохиолдлоор, 10000 хүн амд 14.5-аар тус тус буурсан байна. Халдварт өвчний эрт илрүүлэг, оношилгоо, эмчилгээг сайжруулах зорилгоор ЭМЯ, ХӨСҮТ болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж,	
2.2	Зорилтот бүлгийн нөхөн үржихүйн эмэгтэйчүүдэд гэр бүл төлөвлөлтийн талаар мэдлэг, мэдээлэл олгох ажлыг эрчимжүүлж, жирэмслэхээс сэргийлэх арга хэмжээг нэмэгдүүлнэ.	30.0 Улсын төсөв	Жирэмслэхэ эс сэргийлэх арга хэрэгсэлд хамрагдсан зорилтот бүлгийн эмэгтэйчүүд , хувь	61	62		100
2.3	Зонхилон тохиолдох халдварт өвчний тандалт, эмчилгээний хамрагдалтыг нэмэгдүүлнэ.	250.0 Улсын төсөв	Эмчилгээний хамрагдалт, хувь	95	95		100

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая төгрөгөөр)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	8
						- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Амгалан амаржих газарт цэгт 18м.хүб хүчилтөрөгч үйлдвэрлэх хүчин чадалтай, автомат ажиллагаатай, өрөөнүүдэд хананы холбоосоор хүчилтөрөгчийг шууд дамжуулах, хүчилтөрөгчийн үйлдвэр ашиглалтад орсон.	
Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилго 2: Хүн амын эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тандах, судлах, хянах, эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагааг аж ахуйн нэгж, байгууллага, олон нийт, иргэдтэй хамтран хэрэгжүүлэх замаар Нийгмийн Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ. НХТЖУЧ-2.5, 2.6, 2.11, НЗДУАХ-2.1							
2.1	Зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрт илрүүлгийн хамрагдалтыг нэмэгдүүлэх, шинээр оношлогдсон өвчлөлийн хяналтын чанарыг сайжруулна.	100.0 Улсын төсөв	Эрт илрүүлэгт хамрагдсан хүн, тоо	149942 4	153092 0	-Хүн амын нас хүйс, эрүүл мэндийн эрсдэлт суурилсан халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, оношилгоо, шинжилгээнд нийслэлийн хэмжээнд 149 өрхийн эрүүл мэндийн төв, 46 төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд ажиллаж байна. 2022 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн байдлаар 1,532,592 иргэн хамрагдах ёстойгоос 869,418 иргэн хамрагдсан. Энэ нь нийт хамрагдах ёстой хүн амын 56.7% юм. Нийслэлийн хэмжээнд хамрагдсан хүн амын дунд хоол боловсруулах замын эмгэг хамгийн түгээмэл тохиолдож, зүрх судасны өвчин, бодисын солилцооны хам шинж зэрэг өвчнүүд удаалж байна. -Нийслэлийн хэмжээнд халдварт бус өвчний эрт илрүүлгийг зохион байгуулан ажиллаж 2024 оны эхний 11 сарын байдлаар давхардсан тоогоор 933716 хүнийг хамруулаад байна. Үүнд: 1.Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлэгт 1027326 иргэн хамрагдах ёстойгоос 640472 иргэн хамрагдаж, хамралтын хувь 62.3%. 2.Чихрийн шижин хэв шинж-2 эрт илрүүлэг үзлэгт хамрагдах ёстой 654683 хүнээс 524141 иргэн хамрагдаж, хамралтын хувь 80.1%. 3.Умайн хүзүүний хорт хавдрын эсийн шинжилгээнд суурилсан эрт илрүүлэгт зорилтот насны нийт 28975 (29.5%) эмэгтэй хамрагдсан байна. Үр дүнгийн үзүүлэлтээр нийт эсийн шинжилгээний 2.5 хувь нь Лап зэрэг буюу эсийн түвшинд	100

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая төгрөгөөр)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	8
			Эмчилгээний хамрагдалтын хувь	-	20	шаардлагатай хуульдүүдийн эцэг эхэд эрүүлжүүлэх, цоорол эмчлэх чиглэлээр зөвлөгөө өгч ажилласан. ЧД-ийн Эрүүл мэндийн төв, БНСУ-ын эмч нартай хамтран ЧД-ийн ЕБ-ийн 2 сургуулийн 7800 гаруй хүүхдэд шүд цоорлоос хамгаалах түрхлэг түрхэж, зөвлөгөө өгсөн. -Нэгдсэн Үндэстний байгууллагын хүүхдийн сан, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд нийслэлийн ерөнхий боловсролын 35 сургуульд "Шүд угаах хэсэг" байгуулах төсөл хэрэгжүүлэхтэй холбогдуулан төрийн өмчийн 160 сургуулийн хичээлийн байр, ариун цэврийн байгууламжийн судалгааг гаргав. -Эрүүл мэндийн сайд, Боловсролын сайдын хамтарсан А/413, А/151 дүгээр тушаалын дагуу ЕБС-ийн 1 дүгээр ангийн сурагцагчдын нүд, шүд, зүрхний эмгэгийг эрт илрүүлэх урьдчилан сэргийлэх үзлэг хийх арга хэмжээг зохион байгуулж байна. Энэ дагуу дүүргийн Эрүүл мэндийн төв, ӨЗМТ, хувийн хэвшлийн шүдний эмнэлгүүдтэй хамтран ажиллах гэрээ байгуулсан. Үзлэг зохион байгуулах гэрээ байгуулсан 130 гаруй шүдний эмнэлгүүдийн дунд, их эрсдэлтэй 40 гаруй эмнэлгүүдэд эрүүл ахуй халдаар хамгааллын хяналт тавьж, зөрчлийг арилган ажилласан. Нийслэлийн хэмжээнд ЕБС-ийн 40082 хүүхдэд шүдний урьдчилан сэргийлэх үзлэг, фторт түрхлэг түрхэхээс 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 19998 /50% / хүүхдэд үзлэг хийж, фторт түрхлэг түрхсэн. Эдгээр хүүхдийн 78,8% буюу 14427 шүд цооролтой байна. Дээрх хүүхдүүдийн эцэг, эх, асран хамгаалагч нартай хамтран шүдийг эмчлэн эрүүлжүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна. Түүнчлэн Eguishud.mn сайт дээр амны хөндийн эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан хүүхдийн дата үүсгэн өвчлөлийн байдалд анализ дүгнэлт хийн ажиллах боломж бүрдсэн.	
2.5	Эрэгтэйчүүдийн кабинетийг байгуулна.	-	Кабинет, тоо	4	2	Нийслэлийн хэмжээнд 6 Эрүүл мэндийн төв, 2 нэгдсэн эмнэлэг эрэгтэйчүүдийн кабинетийг байгуулж, андрологийн эмч, урологийн эмчийг байгууллагын захиалгаар мэргэшүүлэн	100

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая төгрөгөөр)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилгот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	8
	/БЗДХ, сүрьеэ болон томуу, томуу төст бусад халдварт өвчин/					мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. -ХБНГУ болон Монгол Улс хоорондын өр хөрвүүлэх хэлэлцээрийн хүрээнд 2025-2030 онд Глобаль сангаар дамжин хэрэгжих төсөлд Нийслэлд сүрьеэгийн идэвхтэй эрт илрүүлийг нэмэгдүүлэх, тусламж үйлчилгээг сайжруулах зорилгоор төсөл боловсруулж /22,6 тэрбум төгрөг/ Глобаль сангийн үндэсний зохицуулах зөвлөлд хүргүүлсэн. -Халдварт өвчнөөс сэргийлэх, түүний тархалтыг хязгаарлах, өвчнийг устгах зорилгоор хүний папиллома вирусийн эсрэг дархлаажуулалтыг заавал хийх үндэсний товлонд оруулсны дагуу НЗД-ын 2024 оны "Хүний папиллома вирусийн эсрэг дархлаажуулалтын тухай" А/1256 дугаар захирамжийг батлуулж, нийслэлийн хэмжээнд дархлаажуулалтыг албан ёсоор ЕБС-ийн 11 настай суралчдын дунд дархлаажуулалтыг зохион байгуулж байна. -“Сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдөр”-ийн хүрээнд 19 төрлийн зорилгот арга хэмжээг зохион байгуулсан. Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлж, үр дүнтэй оношлог, эмчлэх, эрүүл мэндийн байгууллагын байнгын бэлэн байдлыг хангах, төрийн болон төрийн бус байгууллага хоорондын хамтын ажиллагааг уялдуулан ажилласан. БЗДХ-аас урьдчилан сэргийлэх, “Сүрьеэгийн тусламж, үйлчилгээг сайжруулах, сүрьеэгийн идэвхтэй эрт илрүүлэг, хамтын ажиллагаа” зэрэг халдварт өвчний сэдвүүдээр шат дараатай сургалтуудыг зохион байгуулсан. -Нийгмийн зорилтод бүлгийн хүн амын дунд сүрьеэгийн илрүүлтийг эрчимжүүлэн, 20 хувьд хүргэсэн. Төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран “Сүрьеэгүй дүүрэг, хороо” зорилгот хөтөлбөрийн хүрээнд “Сүрьеэ илрүүлэг”-ийг эрчимжүүлсэн. Нийслэлийн 9 дүүргийн Сүрьеэгийн диспансер, кабинетууд нийт 138963 үзлэг хийгдсэнээс урьдчилан сэргийлэх үзлэг 68544 (49.2%) байна. Шинээр илэрсэн сүрьеэгийн 1078 тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 6.7 байна. Өмнөх оны мөн үетэй тохиолдлын тоо ижил буюу 10000 хүн амд 0.2-оор буурсан байна. Нийт тохиолдлын	

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэлж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая төгрөгөөр)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	8
						8.2 хувийг 0-14 насны хүүхэд эзэлж байна. Нийслэлийн хэмжээнд сурьсэгийн эмчилгээнд нийт 1270 хүн хамрагдаж, эмчилгээний хамрагдалт 78,7%, эмчилгээ дуусаж эдгэрэн хяналтаас гарсан 626 хүн байна. Зонхилон тохиолдох бэлгийн замаар дамжих халдварын 5262 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний 32.5 хувийг эзэлж байна. -Элэг бүтэн Монгол үйл ажиллагааны хүрээнд "Гепатитын вирусийн халдварын тандалт, урьдчилан сэргийлэлт, илрүүлэг, оношилгоо, эмчилгээ, хяналт" сэдэвт сургалтыг төвийн 6 дүүргийн өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтэн нарт ХӨСҮТ-тэй хамтран зохион байгуулсан. Тус сургалтад нийт 570 гаруй эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан.	
2.4	3Г-ын 2023 оны 322 дугаар тогтоол: "Эрүүл шүд" арга хэмжээг нийслэлийн хэмжээнд зохион байгуулж, амны хөндийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг өргөжүүлнэ.	-	Урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамрагдсан хүүхдүүд, хувь	-	50	Хүүхдийн амны хөндийн эрүүл мэндийн эрсдэлт хүчин зүйлсийг бууруулан, урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах, амны хөндийн эмгэгийг бууруулах зорилгоор Эрүүл мэндийн сайд, Боловсролын сайдын 2024 оны "Эрүүл шүд" арга хэмжээний төлөвлөгөө /2024-2027/ батлах тухай" А27/А25 дугаар хамтарсан тушаал гарч түүний дагуу нийслэлийн "Эрүүл шүд" арга хэмжээний дэд төлөвлөгөө /2023-2027/-г боловсруулан НЗД-ын 2024 оны А/353 дугаар захирамжаар батлуулсан. Тус төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган дараах арга хэмжээг хэрэгжүүлж байна. Үүнд: -Бага насны хүүхдийн амны хөндийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих зорилгоор нийслэлийн ЕБС-ийн 8-12 насны сурагчдын дунд "Шүд угаалтын аварга" шалгаруулах тэмцээнийг зохион байгуулсан. -Эрүүл сургууль хөтөлбөрийн хүрээнд нийслэлийн 9 дүүргийн 11 сургууль, 1 цэцэрлэгийн нас харгалзахгүй 37634 хүүхдэд амны хөндийн анхан шатны үзлэг хийж, 14872 хүүхдэд шүд цоорлоос хамгаалах түрхэг түрхэж эрүүлжүүлэх	100

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая төгрөгөөр)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	8
						Бэлдэж, мөн бэлгийн замын халдварт өвчний эмчийг богино хэмжээний сургалтад хамруулах замаар хүний нөөцийг бүрдүүлэн, тусламж үйлчилгээг үзүүлж байна. Багануур дүүргийн эрүүл мэндийн төвд эрэгтэйчүүдийн кабинет байгуулсан ч үйлчлүүлэгчид цөөн байгаа тул бэлгийн замын халдварын кабинеттэй хавсран ажиллаж байна. Сүхбаатар дүүргийн эрүүл мэндийн төв нь салбар амбулаторийн барилгыг түшиглэн эрэгтэйчүүдийн кабинетийг 2024 оны IV улиралд байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. Сонгинохайрхан дүүргийн эрүүл мэндийн төв нь эрэгтэйчүүдийн кабинет нээхэд шаардагдах төсвийг дүүргийн 2025 оны төсөвт тусгахаар санал хүргүүлсэн.	
2.6	Анхан болон лавлагаа шатлалын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэгдмэл загварчлалыг боловсруулж, 2 дүүрэгт туршина. /нэгдсэн зохицуулалттай бүсчилсэн сүлжээ-Хан-Уул, Чингэлтэй дүүрэг/	-	үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	10	100	Эрүүл мэндийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын 2021 оны А/678, А/869 дүгээр хамтарсан тушаал, захирамжийн дагуу Чингэлтэй, Хан-Уул дүүрэгт эрүүл мэндийн анхан шатны байгууллага, лавлагаа шатлалын эмнэлгийн уялдаа холбоог сайжруулах, интеграцчиллах, санхүүжилтийг үр дүнтэй зарцуулах, улмаар эрүүл мэндийн анхан шатны байгууллагын үзүүлж буй тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад чиглэгдсэн хөтөлбөрийн цогц үйл ажиллагаа шат дараатай хэрэгжиж байна. Монгол Улсын өвчлөл нас баралтын тэргүүлэх шалтгаан болох зонхилон тохиолдох зүрх судасны (Цусны даралт ихсэх, Чихрийн шижин хэв шинж 2, Дислипидеми) өвчний тусламж үйлчилгээний эмнэл зүйн интеграцчлалын үйл ажиллагаа бөгөөд энэхүү ажлыг гүйцэтгэх хүрээнд НЭМГ-ын даргын А/140 дүгээр тушаалыг баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна. 2024 оны жилийн эцсийн байдлаар Чингэлтэй, Хан-Уул дүүргийн “Зохицуулах зөвлөл”-ийн хурлыг 11 удаа тус тус зохион байгуулж, 2 дүүргийн эрүүл мэндийн төвөөс өрхийн эрүүл мэндийн төвд дэмжлэгт хяналтыг хийсэн. Интеграцлалын хүрээнд Хан-Уул дүүргийн шилжүүлгийн цахим бүртгэл ашиглан нийт 98 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд	100

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая төгрөгөөр)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	8
						шилжүүлгийн эрхийг нээж, 468 хүнийг өрхийн эрүүл мэндийн төвөөс 4 чиглэлээр нарийн мэргэжлийн эмчийн хяналтад шилжүүлснээс нарийн мэргэжлийн эмч нар үзлэг, шинжилгээ хийж 259 үйлчлүүлэгчийг буцаан шилжүүлсэн. Мөн Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн төвийн 11 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, өрхийн эрүүл мэндийн төвийн 92, нийт 103 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд шилжүүлгийн эрхийг нээж, өрхийн эрүүл мэндийн төвөөс 673 хүнийг нарийн мэргэжлийн эмчийн хяналтад шилжүүлснээс нарийн мэргэжлийн эмч нар үзлэг, шинжилгээ хийж 429 үйлчлүүлэгчийг буцаан шилжүүлсэн байна.	
2.7	Гемодиализийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ. /Бөөр орлуулах аппарат/	-	Гемодиализийн аппарат, тоо	27	20	Нийслэлийн харьяа Эрүүл мэндийн байгууллагад 31 гемодиализийн аппарат ажиллаж 133 хүнд бөөр орлуулах эмчилгээг хийж байна. НЭМГ-ын даргын 2024 оны А/160 дугаар тушаалаар гемодиализийн тусламж, үйлчилгээнд дэмжлэгт хяналтыг хийж, харьяа эрүүл мэндийн байгууллагыг мэргэжил арга зүйгээр ханган, шаардлагатай зохицуулалтыг хийж байна. -Багануур дүүргийн эрүүл мэндийн төв, Баянзүрх нэгдсэн эмнэлэг 2024 онд гемодиализийн аппаратыг тус бүр нэгээр нэмэгдүүлсэн. -Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлэгт 584.0 сая төгрөгийн 8 ширхэг гемодиализийн аппаратыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу авахаар техникийн тодорхойлолт боловсруулан Нийслэлийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлж, төндөр шалгаруулалтыг хийж, гэрээ байгуулагдсан. - Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлэгт-5, Нийслэлийн Өргөө амаржих газарт-1, Нийслэлийн Амгалан амаржих газарт-1, Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн төвд-3 нийт 10 ширхэг гемодиализийн аппаратыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу авахаар техникийн тодорхойлолт боловсруулан	90

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая төгрөгөөр)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлгийн хувь
1	2	3	4	5	6	7	8
						Нийслэлийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлж, төндөр шалгаруулалт хийгдэж байна. 2024 онд дүүргийн эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлэг, амаржих газрууд гемодиализийн 20 аппаратаар хангагдаж тусламж, үйлчилгээний хүртээмж нэмэгдэж байна.	
2.8	Стандартын шаардлага хангасан байртай өрхийн эрүүл мэндийн төвийн тоог нэмэгдүүлж, үйлчилгээний хүртээмж, хүчин чадлыг сайжруулна.	-	Стандартын шаардлага хангасан байртай өрхийн эрүүл мэндийн төвийн тоо	14	3	Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр 2023-2025 онд стандартын шаардлага хангасан байртай өрхийн эрүүл мэндийн төвийн барилгыг Хан-Уул, Сонгинохайрхан, Чингэлтэй, Баянзүрх дүүрэгт барихаар төлөвлөсөн. Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хорооны барилга, Хан-Уул дүүргийн 14 дугаар хорооны гүний дулааны худгийн гүйцэтгэгч байгууллагыг сонгон шалгаруулах төндөрийг төсөл хэрэгжүүлэх байгууллага зарласан, Сонгинохайрхан дүүргийн 26 дугаар хорооны зураг төсөвт магадлан хийгдэж байна, Баянзүрх дүүргийн 17 дугаар хорооны гүйцэтгэгчээр "Дагуу" ХХК шалгарсан, барилгын ажил эхэлсэн.	90
Зорилт 3.Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт -Эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох, төлөвлөх, сургах, урамшуулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.							
3.1	Нийслэлийн эрүүл мэндийн байгууллага, ажилчдын ажлын гүйцэтгэлийг үр дүнгээр тооцон үнэлж, урамшуулал олгоно.	400.0 Нийслэл ийн төсөв	Шалгаруулс ан байгууллага , тоо	15	12	Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/881 дүгээр захирамжийн хүрээнд харьяа 28 байгууллагын үйл ажиллагааны үр дүнг үнэлэх, эмнэлгийн шилдэг мэргэжилтэн, ажилтнуудыг шалгаруулах үүрэг бүхий ажлын хэсгийг 2024 оны А/177 дугаар тушаалаар байгуулсан. Эрүүл мэндийн шилдэг байгууллага, шилдэг эмч, сувиллагч, тусгай мэргэжилтэн, эрүүл мэндийн шилдэг ажилтан шалгаруулах квотыг 2024 оны А/172 дугаар тушаалаар баталсан. Шалгуур үзүүлэлтийн дагуу 2 шатны сонгон шалгаруулалтаар нийслэлийн 15 шилдэг эрүүл мэндийн байгууллагыг шалгаруулсан.	100
			Шалгарсан эмч, эмнэлгийн	164	150	Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/881 дүгээр захирамжийн хүрээнд харьяа 28 байгууллагын үйл ажиллагааны үр дүнг үнэлэх, эмнэлгийн шилдэг мэргэжилтэн, ажилтнуудыг шалгаруулах үүрэг бүхий ажлын хэсгийг 2024 оны	100

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая төгрөгөөр)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	8
			Мэргэжилтэ н, тоо			А/177 дугаар тушаалаар байгуулсан. Эрүүл мэндийн шилдэг байгууллага, шилдэг эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн, эрүүл мэндийн шилдэг ажилтан шалгаруулах квотыг 2024 оны А/172 дугаар тушаалаар баталсан. Шалгуур үзүүлэлт, квотын дагуу 2 шатны сонгон шалгаруулалтаар нийт 186 эмнэлгийн мэргэжилтэн, үүнээс 67 шилдэг эмч, 65 шилдэг сувилагч, тусгай мэргэжилтэн, 54 шилдэг эрүүл мэндийн ажилтан шалгаруулан урамшуулсан.	
3.2	Байгууллагын албан хаагчдыг чадавхжуулах сургалт болон ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2024 оны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангана.	-	Хэрэгжилт йн хувь	92	92	Албан хаагчдын ажиллах урам зориг, хүсэл эрмэлзлийг бий болгох, үр бүтээл, тогтвор суурьшилтай ажиллах, албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд эрүүл аюулгүй ажлын байрны нөхцөлөөр хангах, нийгмийн баталгааг хангаж эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд: -Албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэж цалинтай чөлөөг 43 албан хаагчид, нэг удаагийн буцалтгүй тусламж 9 албан хаагчид олгосон. Урт хугацааны сургалтын цалингүй чөлөөг 6 албан хаагчид, -Танин мэдэхүүд суурилсан сэтгэлийн зөрөг чанарыг чадавхжуулах цогц сургалтад 48 албан хаагч, -Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, биелэлтийг тайлагнах, үнэлэх талаар шинээр батлагдсан хууль тогтоомжийн сургалтад 2 албан хаагч, -Төрийн албан хаагчийг удирдлагын академийн 40 цагийн чиглүүлэх багц сургалтад 12 албан хаагчийн төлбөрийг төлж хамруулсан, мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 3, ахлах түшмэлийн сургалтад 6, эрхэлсэн түшмэлийн сургалтад 1 албан хаагчийг сургаж цалинтай чөлөө олгон, ажил үүргийг тасалдалгүй зохион байгуулж, Хүний нөөцийн удирдлага сэдэвт 40 цагийн цахим, танхим хосолсон сургалтад 2 албан хаагч, -Ахлах байцаагчаар 1 албан хаагчийг, төрийн албан хаасан хугацааны нэмэгдэл (60 сар)-ийг 1 албан хаагчид олгож, ахлах түшмэлийн сургалтад 3 албан хаагчийн төлбөр 4,860,000.0	100

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая төгрөгөөр)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлгийн хувь
1	2	3	4	5	6	7	8
						төгрөг, дунд хугацааны давтан сургалт 3 албан хаагчийн төлбөр 4,455,000.0 төгрөг төлж, -Хүний нөөцийг хөгжүүлэх JDS тэтгэлэгт хөтөлбөрийн магистрийн 2 жилийн сургалтад байгууллага, тэтгэлэгт хөтөлбөр, ажилтны хамтран байгуулсан гурван талт гэрээний дагуу ахлах мэргэжилтэн Э.Бсүйг, -“Шинэ ажилтан чиглүүлэх хөтөлбөр”-ийн төлөвлөгөө гарган шинээр томилогдсон 7 албан хаагчийг, -“Төрийн албан хаагчийн ёс зүй, стресс менежмент” сургалтад 60 албан хаагчийг хамруулан зохион байгууллага, Төрийн албаны зөвлөлөөс 4 дэх өдөр бүр зохион байгуулж буй “7:4:10 чиглүүлэх сургалт цахимаар нийт албан хаагчдыг сургалтад хамрууллага. -2-7 хүртэлх насны хүүхэдтэй, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхэд 2024 оны 9 дүгээр сарын 1-нээс 2025 оны 6 дугаар сарын 1-ны өдрийг хүртэл ажлын цагаас 30 минутыг хорогдуулан ажиллах цалгитай чөлөөг 28 ажилтанд олгож ажиллаж байна. -Ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах, өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах дадал, хэвшлийг төлөвшүүлэх үүднээс урьдчилан сэргийлэх эрт илрүүлэгт хамрагдаагүй 29 албан хаагчийг “Family medical” эмнэлэгт үзлэг шинжилгээнд хамруулсан. -Ахмадын баярын өдрөөр тус газраас тэтгэвэрт гарсан 93 ахмад настныг хүлээн авч, гарын бэлэг өглөө. Харьяа байгууллагын албан хаагчдын ажиллах хүсэл эрмэлзлийг бий болгох, үр бүтээл, тогтвор суурьшилтай ажиллах, албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд эрүүл аюулгүй ажлын байрны нөхцөлөөр хангах, нийгмийн баталгаат хангаж эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд: -Эрүүл мэндийн салбарт үйлдэгдэж байгаа гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, цаашид анхаарах асуудал сургалтад харьяа болон газрын нийт 122 албан хаагч,	

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая төгрөгөөр)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	8
3.3	Нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй худалдаа, нийтийн хоол,	-	Төрийн болон хувийн	288	354	“Төрийн албан хаагчийн хариуцах ажил, үйлчилгээ, асуудал шийдвэрлэх арга зам” сургалтад 57 албан хаагч, - БНСУ-н буцалтгүй тусламжийн хүрээнд 60,000 ам.долларын эмч болон сувилагч нарыг чадавхижуулах сургалтын төслийг СЯ, ЭМЯ болон НТГ-т хургуулсан. -Нийслэлийн харьяа эрүүл мэндийн байгууллагын удирдах ажилтнуудыг Төрийн удирдлагаар мэргэшүүлэх болон сертификатын сургалтад хамруулахаар нэгдсэн судалгааг авч, 18 эрүүл мэндийн төвийн 22 удирдах ажилтнууд дээрх сургалтад 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрөөс 7 хоногийн 2 өдрийн бүтэн танхимын сургалтад, - Харьяа эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлгийн эмч, сувилагч нарт мэргэшүүлэх, стресс менежмент, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээний, архив албан хэрэг хөтлөлт зэрэг 36 удаагийн сургалт, - Харьяа эрүүл мэндийн байгууллагын 22 эмч, сувилагч төгсөлтийн дараах мэргэжил дээшлүүлэх сургалтад төрийн сангийн санхүүжилтээр, -Хөгжлийн төвтэй хамтран БНХАУ-н Өвөр монголын өөртөө засах орны нийслэл Хөх хотод 2 эмчийг тус тус суралцуулсан. - Эрүүл мэндийн ажилтны төгсөлтийн дараах сургалтад 2024-2025 оны хичээлийн жилд улсын төсвийн санхүүжилтээр төгсөлтийн дараах мэргэжил дээшлүүлэхэд 10 эмч, сувилагч суралцаж төгссөн бөгөөд Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирлын 2024 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн А/84 дүгээр тушаалаар гэрчилгээг олгосон. - Мөн 2024 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн байдлаар Анхан шатны эрүүл мэндийн байгууллагад 3 жил ба түүнээс дээш хугацаагаар тасралтгүй ажилласан 98 эмч, сувилагчид Эрүүл мэндийн тухай хуулийн 29.2 дахь заалтын дагуу 2.543.9 сая төгрөгийн тэтгэмж олгосон. Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газраас ирүүлсэн 7 удирдамжийн хүрээнд 356 төрийн болон хувийн	100

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая төгрөгөөр)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлтийн хувь
1	2 Үйлдвэрлэл үйлчилгээний байгууллагад төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийх, холбогдох хууль тогтоомж, тушаал шийдвэр, стандартын хэрэгжилтийг хангуулна.	3	4 хэвшлийн эрүүл мэндийн байгууллага, тоо	5	6	7 хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад төлөвлөгөөт дэмжлэгт, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ.	8
		-	Ахуйн болон төв цэвэрлэх байгууламж, ус түгээх байр, тоо	275	225	1. Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газрын даргын баталсан 10-00/28 дугаартай удирдамжийн хүрээнд Төв цэвэрлэх байгууламж, Дамбадаржаа, Чингэлтэй, Нисэх, Биокомбинат, Харгиа урьдчилан цэвэрлэх байгууламж зэрэг нийт 6 газраас 14 дээж авч, нян судлалын 3, химийн 4 үзүүлэлтээр Нийслэлийн лабораторид шинжлүүлэхэд 36 хувь нь Хүрээлэн буй орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS4943:2015 стандартыг хангаагүй гарсан байна. Шинжилгээний хариуг үндэслэн улсын байцаагчийн 6 дүгнэлт, 1 албан шаардлагаар хугацаатай үүрэг өгч, биелэлтийг тооцсон. 2. Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газрын даргын баталсан 2 удирдамжийн хүрээнд 374 түний худал, ус түгээх байр, шинээр баригдсан барилгын хэрэглэгчийн цэгээс 905 сорьц авч, нян судлалын 3, химийн 11, хүнд металлын 4 үзүүлэлтээр Нийслэлийн лабораторид шинжлүүлэхэд 17.1 хувь нь Хүрээлэн буй орчин. Эрүүлийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүйн байдлын үнэлгээ" MNS 0900:2018 стандартын шаардлага хангахгүй гарсан байна. Шинжилгээний дүнг үндэслэн 169 дүгнэлт гарган, 13 албан шаардлагаар үүрэг өгч, 4 аж ахуйн нэгжид 8000.0 мянган төгрөгийн шийтгэл ногдуулан бүрэн барагдуулан, 40 газраас давтан сорьц авч, стандартын шаардлага хангуулсан.	100

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая төгрөгөөр)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	8
		-	Худалдаа, нийтийн хоол, үйлдвэрлэл үйлчилгээний газар, тоо	680	741	Хүнсний худалдаа, нийтийн хоол, үйлдвэрлэл үйлчилгээний байгууллагад төлөвлөгөөт хяналт шалгалт хийхээр зарлагдсан 304 объектоос 259, төлөвлөгөөт урьдчилан сэргийлэх хяналт шалгалтад 1397 объект тус тус хамрагдсан. Хяналтаар 2241 зөрчил илрүүлэн 1685 (75.1%) зөрчлийг газар дээр нь болон хугацаатай үүрэг даалгавар өгч арилгуулж, зөрчлийн үр дагаварыг арилгуулахаар 51 заалт бүхий 24 албан даалгавар, 765 заалт бүхий 119 албан шаардлагыг хугацаатай хүргүүлж, цаашид үүсч болох эрсдэлээс сэргийлэх зорилгоор 166 заалт бүхий 18 улсын (ахлах) байцаагчийн зөвлөмж хүргүүлэн, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч, гүйцэтгэлийн хяналтаар 93.8 хувьтай биелэгдсэн. Зөрчилд холбогдуулж 27 хуулийн этгээд, 11 иргэнд 34550.0 мянган төгрөгийн шийтгэл оногдуулж, 811.0 мянган төгрөгийн нөхөн төлбөрийг бүрэн барагдуулсан.	100
3.4	Иргэн, аж ахуй нэгж, байгууллагын өргөдөл, хүсэлт, гомдол, мэдээлэл, эрх бүхий байгууллагын шийдвэрээр төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийнэ.	-	Өргөдөл гомдлын шийдвэрлэл т, хувь	96	97	Тайлант хугацаанд ирсэн 648 өргөдөл, гомдол болон эрх бүхий байгууллагын шийдвэрийн хүрээнд 2889 объектод төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, шалгалтын явцад 1614 зөрчил, дутагдал илрүүлэн 1342 зөрчлийг арилгуулан, улсын /ахлах/ байцаагчийн 466 заалт бүхий 166 албан шаардлага хүргүүлэн, 135 аж ахуй нэгж, байгууллага, иргэнд 199400.0 мянган төгрөгийн шийтгэл ногдуулан, 135 аж нэгж, байгууллага, иргэнд эрхий албан тушаалтны албан даалгавар хүргүүлэн, гүйцэтгэлийг тооцож, хуулийн хугацаанд шийдвэрлэн ажилласан.	100
			Зөрчил арилгуулалт, хувь	79.0	80.0	Тайлант хугацаанд 2889 объектод төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийсэн шалгалтын явцад 1614 зөрчил, дутагдал илрүүлэн 1342 зөрчил буюу 83.2%-ийг арилгуулсан.	100
3.5	Их эрсдэлтэй үнэлэгдсэн объектод төлөвлөгөөт хяналт шалгалт зохион байгуулна.	-	Хууль сахин мөрдөлтийн түвшин, тоо	71	82	1.Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газрын даргын баталсан 5 удирдамжийн хүрээнд 699 аж ахуйн нэгж, байгууллага, иргэний үйл ажиллагааг 14 хяналтын хуудааар төлөвлөгөөт хяналт шалгалт хийж, эрсдэлийг үнэлэхэд хууль сахин мөрдөлтийн түвшин 60-85 хувьтай байна.	90

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая төгрөгөөр)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилгот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	8
			Эрсдэл үүсэх магадлал, хувь	29	26	Төлөвлөгөөт хяналт шалгалтанд хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллага, иргэний үйл ажиглалааг хяналтын хуудсаар шалган, эрсдэлийг үнэлэхэд их эрсдэлтэй 19, дунд эрсдэлтэй 353, бага эрсдэлтэй 327 байсан бөгөөд эрсдэл үүсэх магадлал 26-50 хувь байна.	80
			Зөрчил арилгуулалт, хувь	51	72	Төлөвлөгөөт хяналт шалгалтын явцад 5987 зөрчил, дутагдал илрүүлэн, 3770 зөрчлийг арилгуулан, улсын /ахлах/ байцаагчийн 2332 заалт бүхий 372 албан шаардлага хүргүүлэн, 67 аж ахуй нэгж, байгууллага, иргэнд 70550.0 мянган төгрөгийн шийтгэл ногдуулан, 67 аж нэгж, байгууллага, иргэнд эрхий бүхий албан тушаалтны албан даалгавар хүргүүлэн, гүйцэтгэлийг тооцож ажигласан. Зөрчил арилгуулалт 63 хувь.	90
3.6	Барилга байгууламж барих газар олголт зураг төсөл зохиох, ашиглалтад хүлээн авахад эрүүл ахуйн урьдчилсан хяналт хийж дүгнэлт гаргана.	-	Хамрагдсан объект, тоо	766	Хүсэлтээр	Барилга байгууламжийн зураг төсөлд эрүүл ахуйн хяналт хийх 458 хүсэлтийн дагуу Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газрын даргын баталсан 10-00/02 дугаартай удирдамжийн хүрээнд нийт 421 барилгын зурагт хяналт хийж, улсын /ахлах/ байцаагчийн дүгнэлт гарган барилгын зураг төслийг баталгаажуулав. Тус удирдамжийн хүрээнд шинээр баригдсан барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авах улсын комиссын бүрэлдэхүүнд нийт 11 улсын байцаагч ажиллан, 103 барилга байгууламжийг үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээн авсан байна.	90
			Зөрчил арилгуулалт, хувь	96	96.5	Барилга байгууламжийн зураг төсөлд эрүүл ахуйн хяналт хийхэд болон байнгын ашиглалтад оруулахад Эрүүл ахуйн тухай хуулийн холбогдох заалтыг зөрчсөн 25 байгууллага, аж ахуйн нэгжид 63500.0 мянган төгрөгийн шийтгэл ногдуулж, бүрэн барагдуулав.	100
			Стандартын шаардлага хангасан объект, тоо	701	Тухайн жилд	Барилга байгууламжийн зураг төсөлд эрүүл ахуйн хяналт хийхэд холбогдох барилгын норм дүрэм стандартын шаардлага хангасан объект 243 байна.	100

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая төгрөгөөр)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	8
3.7	Нийтийг хамарсан баяр ёслол, цаг үеийн шаардлагаар буй арга хэмжээнд урьдчилан сэргийлэх шалгалт хийнэ.	-	Шалгалтад хамрагдсан объект, тоо	4400	4500	Нийтийг хамарсан баяр ёслол /сар шинийн баярыг утгасан өргөтгөсөн худалдааны үед 885, хүүхдийн баярын үеэр 1163, үндэсний их баяр наадмын үед 1056 аж ахуйн нэгж, иргэн/ болон цаг үеийн шаардлагаар 8 удирдажигийн хүрээнд нийт 4502 объектын хүнсний худалдаа үйлчилгээ, хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийсэн.	100
			Зөрчил арилгуулалт, хувь	85.0	85.5	Урьдчилан сэргийлэх хяналтаар нийт 2071 зөрчил дутагдал илрүүлэн 1650 буюу 79.67%-ийг арилгуулж, илэрсэн зөрчил арилгуулахаар 31 аж ахуйн нэгж, иргэнд 108 заалт бүхий 31 албан шаардлагаар хугацаатай үүрэг даалгавар өгч, 157 заалт бүхий 17 зөвлөмж хүргүүлэн, 578 ширхэг, 233 кг бүхий 3271.25 мянган төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг хурааж устгасан. Энэ хүрээнд 18 хуулийн этгээдэд 40000.0 мянган төгрөгийн шийтгэл оногдуулж, 5 аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд эрхий бүхий албан тушаалтны албан даалгавар хүргүүлэн биелэлтийг тооцон ажиглав. Хяналтаар согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх, тамхи худалдаалах газрын үйл ажиллагааны 1137, үйлдвэрийн ажлын байрны 3, бүтээгдэхүүний 20 дүгнэлт тус тус гаргасан.	93
3.8	"Сайн туршлага - 2024" арга хэмжээг зохион байгуулна.	-	Оролцсон байгууллагын тоо	53	60	Сайн туршлага-2024 арга хэмжээг 2 үе шаттай зохион байгууллаа. Сайн туршлага-2024 арга хэмжээний 2 дугаар шатны үйл ажиллагааг 10 дугаар сарын 22-26-ны өдрүүдэд зохион байгуулж нийслэлийн 70 эрүүл мэндийн байгууллагын 242 бүтээгээс 6 төрлөөр шилдгүүдийг шалгаруулж, өргөмжлөл, батламж олгон урамшууллаа. Арга хэмжээнд оролцсон бүтээгээр үзэсгэлэн гарган нийслэлийн бусад эрүүл мэндийн байгууллагуудад сурталчлан, 800 гаруй эмч, эмнэлгийн мэргэжилтэн харилцан туршлагаа хуваалцсан.	100

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая төгрөгөөр)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	8
3.9	Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулж, өр авлага үүсгэхгүй байх, төсвийн гүйцэтгэлийг хугацаанд хуулийн тайлангаж ажиглана.	-	2023 оны зайлшгүй хэвшүүлэх бүтээлийн тоо	5	5	Сайн туршлага-2023 арга хэмжээнд оролцсон бүтээлүүдээс эмнэлгийн тусламж, үйлчилгээг сайжруулах, ажлын үр бүтээмжийг нэмэгдүүлэх 6 сайн туршлага ("Сувилагч нарт зориулсан гарын авлага", "Сувилахуйн тусламж үйлчилгээнд iPad технологийг нэвтрүүлсэн нь", "Сувилахуйн албаны бүтэц, зохион байгуулалтын шинэчлэл", "Андрологийн тусламж үйлчилгээг нэвтрүүлсэн нь", "Зүрх судасны болон элэгний эмгэгийн хүндрэл нас баралтыг бууруулах өрхийн эмчийн хяналтын аргачлал", "Харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан мэдээллийн үйлчилгээ")-ыг 2024 онд зайлшгүй хэвшүүлэх бүтээлээр сонгон хэвшүүлсэн.	100
			2023 оны бүтээлийг хэвшүүлсэн байгууллагын тоо	12	20	Сайн туршлага-2023 арга хэмжээний зайлшгүй хэвшүүлэх 6 бүтээлийг 2024 онд харьяа 20 эрүүл мэндийн байгууллага хэвшүүлсэн.	100
			Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн тоо	12	12	Төсвийн гүйцэтгэлийн тайланг 2024 онд 12 удаа хугацаанд нь тайлагнаж, Эрүүл мэндийн яаманд тухай бүр хүргүүлсэн. Тайланг хугацаанд өр авлага үүсээгүй байна.	100

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая төгрөгөөр)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	8
3.10	Улс, нийслэлийн төсөв болон бусад эх үүсвэрээр 2023-2024 онд нийслэлд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, санхүүжилтийн үйл ажиллагааг Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох журамд нийцүүлэн ил тод шуурхай, зохион байгуулж хугацаанд нь чанартай гүйцэтгэнэ.	-	Үйл ажиллагаан ы хэрэгжилт, хувиар	-	100	Нийслэлийн эрүүл мэндийн газрын хөрөнгө оруулалтын дансаар Улс, нийслэлийн төсөв болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний 1,076.4 сая төгрөгийн 3 гүйцэтгэл, 159.9 сая төгрөгийн 9 ажлын барьцаа шилжиж орж ирсэн. Төсөл, арга хэмжээний зардлыг Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн дагуу Нийслэлийн Засаг даргын тамгын газрын хөрөнгө оруулалтын хэлтэс, төрийн сангийн хэлтсээр хянуулж тус тус олгосон.	100
3.11	Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний ажилд захиалагчийн хяналт тавьж ажиллахдаа холбогдох хууль, журамд нийцүүлэн, үнэн зөв, бодитой тайлагнаж, мэргэжлийн байгууллага хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулан, тулгамдсан асуудлыг тухай бүр шийдвэрлэж, хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийн бүх үе шатанд тавих хяналтыг сайжруулж ажиллана.	-	Үйл ажиллагаан ы хэрэгжилт, хувиар	-	100	Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/133 дугаар захирамжийн дагуу 8 төсөл, арга хэмжээ, Нийслэлийн засаг даргын 2024 оны А/156 захирамжийн дагуу 8 төсөл, арга хэмжээ нийт 20 арга хэмжээний захиалагчийн хяналтыг холбогдох хууль, журамд нийцүүлэн, үнэн зөв, бодитой тайлагнаж ажиглаж байна.	100

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая төгрөгөөр)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлгийн хувь
1	2	3	4	5	6	7	8
3.12	Дунд хугацааны бодлогын баримт бичиг Стратеги төлөвлөгөө батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллана.	-	Батлуулсан стратеги төлөвлөгөө хэрэгжилтийг хувь	-	1	- Эрүүл мэндийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн "Эрүүл мэндийн салбарын 2022-2025 оны стратеги төлөвлөгөө батлах тухай" А/609 дүгээр тушаалаар Эрүүл мэндийн салбарын 2022-2025 оны стратеги төлөвлөгөө батлагдсан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. - Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн "Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийг 24/08 дугаар тогтоолоор баталсан. Энэ дагуу Нийслэлийн Эрүүл мэндийн салбарын 2024-2028 оны стратеги төлөвлөлтийн төслийг боловсруулан бэлэн болгоод байна. Нэгдсэн журмаар батлуулах хугацааг хүлээж байна. - Эрүүл мэндийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024 онд хамтран ажиллах тэрээ, Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийг 2024 онд хөгжүүлэх төлөвлөгөөнд туссан заалт, арга хэмжээний хэрэгжилтийг ханган, тайлангийн хугацаанд нэгтгэн, холбогдох дээд шатны байгууллагуудад хүргүүлэн, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100
3.13	Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн тодорхой төлөвлөн хэлэлцүүлэх, түүнийг хэрэгжүүлэх, тайлагнана.	-	Хэлэлцүүлэх асуудал, тоо	-	2	Нийслэлийн Эрүүл мэндийн газраас 2024 онд Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар: - Улаанбаатар хотын унд ахуйн ус, хөрс, бохир усны шинжилгээний дүн, цаашид авах арга хэмжээний саналыг, - Нийслэлийг 2025 онд хөгжүүлэх төлөвлөгөөнд тусгах заалт, арга хэмжээний саналыг, - Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн эрүүл мэндийн байгууллагын хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг тус тус хэлэлцүүлсэн.	100
3.14	Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн	-	Үйл ажиллагаан	2	2	Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн төлөвлөгөөний эрүүл мэндийн салбарын	100

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая төгрөгөөр)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	8
	төлөвлөгөөний 2024 оны хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, ЗДТГ-т хүргүүлнэ.		хэрэгжилт, хувь			хэрэгжүүлэх 7 зорилт 12 арга хэмжээ, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн нийслэлийн эрүүл мэндийн салбарын хэрэгжүүлэх 1 арга хэмжээний хэрэгжилтийг тус тус ханган, дүн шинжилгээ хийж НЗДТГ-т EEP нэгдсэн цахим системээр хугацаанд нь тайлагнан ажиглаж байна.	
3.15	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, ЗДТГ-т хүргүүлнэ.	-	үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	2	2	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний эрүүл мэндийн салбарын хэрэгжүүлэх 23 арга хэмжээний хэрэгжилтийг ханган, дүн шинжилгээ хийж НЗДТГ-т EEP нэгдсэн цахим системээр 3 удаа тайлагнасан.	100
3.16	Нийслэлийг хөгжүүлэх 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, ЗДТГ-т хүргүүлнэ.	-	үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	2	2	Нийслэлийг хөгжүүлэх 2024 оны төлөвлөгөөний эрүүл мэндийн салбарын хэрэгжүүлэх 25 арга хэмжээний хэрэгжилтийг ханган, хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж 2024 оны II, III улиралд EEP нэгдсэн системийн Хяналт шинжилгээний үнэлгээний программаар тайлагнасан.	100
3.17	Улс, нийслэлийн дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт туслуулах санал боловсруулж хүргүүлэх	-	Арга хэмжээний тоо	-	5	"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийг ханган ажиглаж байна. Энэ хүрээнд - Эрүүл мэндийн байгууллагын барилга байгууламжийг шинээр барих, өргөтгөх, засварлах, стандартын шаардлага хангасан тохижилт, үйлчилгээний орчныг бүрдүүлэх чиглэлээр улсын болон нийслэлийн төсөвт санал тусгуулан ажигласан. - 2024 оны 01 дүгээр сард "Нийгмийн эрүүл мэндийн тухай" хууль шинээр батлагдсаны дагуу дүүргийн эрүүл мэндийн төвийг Нэгдсэн эмнэлэг, Нийгмийн эрүүл мэндийн төв болгон зохион байгуулалт хийнэ. Эрүүл мэндийн яам холбогдох журам, стандартыг боловсруулж байгаа бөгөөд ажлын хэсэгт тус газрын албан хаагчид чиглэл чиглэлээрээ ажиглаж байна. Мөн тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх хүрээнд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Баянзүрх дүүргийн 8-р хороо, Эрдэнэтөлгойн нутаг дэвсгэрт Ахмад настан, хүүхдийн	100

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая төгрөгөөр)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	8
3.18	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд хавар, намрын улиралд мод тарих.	-	Тарьсан модны тоо	-	100	зориулалттай 7 давхар, 2570.8 мкв, 100 ортой эмнэлгийн барилга, 5-р хороо, хуучин сурьээгийн диспансерийн суурин дээр 4 давхар 1435.3 мкв Нийгмийн эрүүл мэндийн төвийн барилгыг тус тус ашиглалтад оруулсан. Дээрх 2 эмнэлэгт шаардлагатай тоног төхөөрөмжийн төсөв болох 6.4 тэрбум төгрөгийг 2024 оны нийслэлийн төсвийн тодотголоор шийдвэрлүүлсэн. - 2025 онд Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар ашиглалтад орох Гачуурт тосгоны эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж 3 тэрбум, хүүхдийн сэргээн засах "Бацхан тэмүүлэл төв"-ын сувиллын барилгын зураг төсвийн 200 сая төгрөгийг шийдвэрлүүлэн ажиглаж байна. - Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийг хөгжүүлэх 2024 оны төлөвлөгөө, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгах саналыг боловсруулан НЗДТГ-т тус тус хүргүүлсэн. Ойн тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн "Мод тарих үндэсний өдөр зарлах тухай" 2010 оны 63 дугаар зарлиг, "Засгийн газарт чиглэл өгөх тухай" 2021 оны 58 дугаар зарлиг, Монгол Улсын Засгийн газрын "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний талаарх авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2021 оны 350 дугаар тогтоол, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын "Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр"-ийн арга хэмжээг зохион байгуулах тухай 2024 оны А/238 дугаар тушаал, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчтай байгуулсан "Байгаль орчин, аялал жуулчлалын салбарт хамтран ажиглах" Д/24-22 дугаар гэрээний хэрэгжилтийн хүрээнд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, ой, усны нөөцийг хамгаалж нэмэгдүүлэх, экологийн тэнцвэрт байдлыг хангах, мод тарих соёлыг түгээн дэлгэрүүлэх, олон нийтэд сурталчлан таниулах чиглэлээр зохион байгуулах 2024 оны хаврын мод тарих арга	100

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая төгрөгөөр)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлгийн хувь
1	2	3	4	5	6	7	8
						хэмжээг "Ногоон хот-Иргэний оролцоо", "Арчлахгүй бол Ургахгүй" уриан д Нийслэлийн эрүүл мэндийн газар нь нэгдэж 2024 оны 5 дугаар сарын 31, 10 дугаар сарын 06-ны өдөр Хан-Уул дүүрэг, 14 дүгээр хороо, Айцын давааны ам байршилд "улиас, агч, бүргас, чацаргана" зэрэг 5 төрлийн 20 ширхэг мод тарьж, урд жилүүдэд тарьсан 5 төрлийн 120 ширхэг модыг услан, арчилж, орчны хогийг цэвэрлэлээ.	
3.19	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангахад холбогдох байгууллагатай хамтран ажиллана.	-	Хуулийг сурталчилсан н арга хэмжээний тоо	1	3	Эрүүл мэндийн сайдын 2024 оны Жендэрт суурилсан болон гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээний 2024-2026 оны арга хэмжээний төлөвлөгөөг харьяа эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлсэн. Тус төлөвлөгөөний хүрээнд: -Эрүүл мэндийн байгууллагын 500 орчим албан хаагч нарт мэдээлэл хийсэн, -Узлаг оношилгоо шинжилгээ хийлгэхээр эмнэлэгт хандаж буй иргэн бүрт хүчирхийллийн үл мөр олсон тохиолдолд хамтарсан багт шилжүүлэх, эрсдэл тооцоолох, хүчирхийлэлд өртсөн иргэнд тусламж үйлчилгээ үзүүлэх талаар мэдээллийг тус тус өгсөн. -Нийслэлийн Засаг даргын тамгын газарт "Жендэрийн үндэсний хорооны даргын үүрэг даалгавар"-ын хэрэгжилтийг тогтоосон хугацаанд тайлагнаж, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах ажлын хүрээнд 4 төрлийн судалгаа гарган хүргүүлсэн.	100
3.20	Нийтийг хамарсан баяр ёслол, цаг үеийн асуудлаар иргэдэд мэдээ мэдээлэл хүргэх	-	Арга хэмжээ зохион байгуулсан тоо	5	5	Нийтийг хамарсан баяр ёслол, улирал, цаг үетэйгээ уялдуулж "Нийслэлийн Эрүүл мэндийн газар" гэсэн цахим хаяг болон олон нийтийн сүлжээгээр иргэд, олон нийтэд чиглэсэн мэдээлэл сурталчилгаа, цаг үеийн нөхцөл байдал, сэрэмжлүүлэг, зөвлөмж, бодит үр дүнг харуулсан мэдээ мэдээллийг тогтмол хүргэж байна. Мөн нийслэлийн 9 дүүргийн эрүүл мэндийн төв, Өрхийн эрүүл мэндийн төвийн цахим хуудсаар цаг үеийн нөхцөл байдал,	100

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэлж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая төгрөгөөр)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлгийн хувь
1	2	3	4	5	6	7	8
						мэдээлэл сурталчилгаа, олон нийтийг хамарсан баяр наадмын үеийн сэрэмжлүүлэг, зөвлөмжийг хүргэдэг. Тухайлбал: - Шар усны үерээс иргэдийг урьдчилан сэргийлэх үүднээс "Үер усны аюулаас сэргийлэх" үерийн дараах зөвлөмж, үерийн дараа цэвэрлэгээ халдваргүйжүүлэлт хийх зөвлөгөө" 4 сэдэвт сэрэмжлүүлэг постерийг иргэдэд нийслэлийн харьяа дүүргийн эрүүл мэндийн төвүүдийн цахим пэйж хуудсаар дамжуулан нийт 73773 хүнд хүргэсэн. - 9 дүүргийн эрүүл мэндийн төвийн цахим хуудсаар дамжуулан хоол хүнс, гараар дамжих халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тухай 5 төрлийн зөвлөмж материалыг 89387 хүнд хүргэн ажигласан. - Нийслэлийн хэмжээнд 154 хорооны ӨЗМТ-с зорилтот бүлэгт чиглэн цахимаар: -Гэдэсний халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар нийт 149 удаагийн давтамжтайгаар 67053 иргэнд, -Ундны усны бохирдол хүн амд нөлөөлөх сэдвээр нийт 243 удаагийн давтамжтайгаар 74961 иргэнд, -Ус, хүнсний бохирдлоос шалтгаалсан халдварт өвчний голломтын хариу арга хэмжээ сэдвээр нийт 144 удаагийн давтамжтайгаар 26296 иргэнд эрүүл мэндийн боловсрол олгосон.	
Зорилт 4. Дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт - Эрүүл мэндийн байгууллагуудын материаллаг бааз, барилга, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, автомашин ашиглалт, засвар үйлчилгээ нөхөн хангалтыг нэгтгэн зохион байгуулна. /НЗД-ын 2022 оны А/495 дугаар захирамж/							
4.1	Дүүргийн эрүүл мэндийн төвийг түшиглэн "Эрүүл мэндийг дэмжих төв"-ийг шинээр байгуулна.	-	Дэмжих төв, тоо	3	2	Нийслэлийн хэмжээнд нийт 5 /ХУДЭМТ, СХДНЭ, СХДЭМТ, ЧДЭМТ, БЗДЭМТ/эрүүл мэндийг дэмжих төв ажиллаж байна. Эдгээр төвөөр дамжуулан иргэдийн эрүүл мэндийн эрсдэлт суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бүс өвчний урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг, оношилгоог зохион байгуулан ажиглаж байна.	100

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая төгрөгөөр)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	8
4.2	"Нийгмийн эрүүл мэндийн төв"-ийн барилгын ажлыг үргэлжлүүлнэ.	819.1 Улсын төсөв	Барилгын угсралтын ажлын гүйцэтгэл, хувь	10	90	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Баянзүрх дүүрэгт Нийгмийн эрүүл мэндийн төвийн барилгын ажлын 3.9 тэрбум төгрөгөөр гүйцэтгэхээр "Шилдээд" ХХК гэрээ байгуулсан. Барилгын байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн. 2024 оны батлагдсан төсөв 819.2 сая, гүйцэтгэл 819.2 сая төгрөг. Барилга угсралтын ажил 100 хувийн гүйцэтгэлтэй бүрэн дуусч 2024 оны 05 дугаар сард ашиглалтад оруулсан. Дээрх эмнэлэгт шаардлагатай тоног төхөөрөмжийн төсөв болох 1.4 тэрбум төгрөгийг 2024 оны нийслэлийн төсвийн тодотголоор шийдвэрлүүлсэн.	100
4.3	Жишиг өрхийн эрүүл мэндийн төвийн тоог нэмэгдүүлж, үйлчилгээний хүртээмж, хүчин чадлыг сайжруулах ажлыг эхлүүлнэ. /Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүрэг/	1,800.0 Гадаады н зээл, тусламж /АХБ/	Барилгын угсралтын ажлын гүйцэтгэл, хувь	10	50	Монгол Улсын Засгийн газар, Азийн хөржлийн банк (АХБ)-ны хооронд байгуулсан гэрээний дагуу хэрэгжиж буй "Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр" төслийн хүрээнд салбар хоорондын ажлыг уялдуулан зохицуулах, төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэн ажиллаж байна. 1. Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хорооны барилгын ажлыг 3.2 тэрбум төгрөгөөр гүйцэтгэхээр "Юузат Эрдэнэ" ХХК гэрээ байгуулагдсан. Барилгын ажил суурь цутгалтийн ажил бүрэн дууссан. Суурийн шороо дүүргэлтийн ажил үргэлжилж ажлын гүйцэтгэл 19 хувьтай байна. 2. Хан-Уул дүүргийн 14 хорооны гүний дулааны худгийн гүйцэтгэгч байгууллагыг сонгон шалгаруулах тендерийг төсөл хэрэгжүүлэх байгууллага зарласан боловч тендер сонгон шалгаруулалт амжилтгүй болсон. Сонгон шалгаруулах тендер дахин зарлагдсан. 3. Сонгинохайрхан дүүргийн 26 хорооны зураг төсөвт магадлан хийгдэж дууссан. Барилгын ажлын гүйцэтгэгч байгууллагыг сонгон шалгаруулах тендерийг төсөл хэрэгжүүлэх байгууллага зарлаж, 2024 оны 11 дүгээр сарын	84

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая төгрөгөөр)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	8
						27ны өдөр төндөрийн нээлт хийгдэж сонгон шалгаруулалт явагдаж байна. 4. Баянзүрх дүүргийн 17 дугаар хорооны гүйцэтгэгчээр "Далу" ХХК шалгарсан, барилгын ажил эхэлсэн боловч барилгажих талбайн хөрснөөс ус гарч, барилгын батлагдсан зураг өөрчлөгдөж дахин магадлан хийгдсэн.	
4.4	Эрүүл мэндийн байгууллагуудын барилгын их засварын ажлыг хийнэ. /ХУДНЗ, НДЭМТ, СХДЭМТ/	1,058.2 Нийслэл ийн төсөв	Их засвар хийгдсэн барилга, тоо	-	2	Хан-Уул нэгдсэн эмнэлэг, Налайх, Сонгинохайрхан дүүргийн эрүүл мэндийн төвийн барилгын их засвар хийх ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулалтыг НХААГ зохион байгуулсан. Захиалагчийн хяналтыг НХОГ хариуцан ажиллаж байна. Дээрх 3 эрүүл мэндийн байгууллагын засварын ажил бүрэн дууссан. 2024 оны батлагдсан төсөв 1,000.0 сая	100
4.5	Харьяа эрүүл мэндийн байгууллагуудыг тоног шаардлагатай төхөөрөмжөөр хангана.	-	Нэмэгдүүлс эн тоног төхөөрөмж, тоо /мэс засал, ходоодны дуран, дижитал рентген/	-	27	2024 онд Улсын төсвийн хөрөнгөөр 6,247.5 сая төгрөгийн тоног төхөөрөмж, нийслэлийн төсвийн хөрөнгөөр 950.4 сая төгрөгийн автомашинаар хангасан. Түүнчлэн нийслэлийн төсвийн тодотголоор 12.3 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмжийн төсвийг батлуулсан Нийслэлийн худалдан авах ажиллагааны газарт төндөр сонгон шалгаруулалт үргэлжилж байна. Тухайлбал: Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/133 дугаар захирамжийн дагуу 8 төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт тавьж ажиллаж байна. Нийт 12 ажлын 9 ажил нь бүрэн хэрэгжсэн, 2 ажил нь гэрээ байгуулан ажил хийгдэж байна, 1 ажлын төндөр сонгон шалгаруулалт амжилттай болж, Броун Айс ХХК шалгарч гэрээ байгуулах эрх олгогдсон байна. Хэрэгжсэн 9 ажлын хүрээнд харьяа эрүүл мэндийн байгууллага, өрхийн эрүүл мэндийн төвд нийт 821 ширхэг эмнэлгийн тусламж үйлчилгээнд шаардлагатай тоног төхөөрөмж, 7 ширхэг суудлын автомашинаар хангаж ажилласан. Нийслэлийн засаг даргын 2024 оны А/156 дугаар захирамжийн дагуу 8 төсөл, арга хэмжээний захиалагчийн хяналт тавьж ажиллаж байна. Тус ажлуудын техникийн	100

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая төгрөгөөр)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	8
						Тодорхойлолтыг боловсруулан Нийслэлийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн. Төндөр сонгон шалгаруулалт үргэлжилж байна.	
4.6	Нийслэлийн Аддиктологийн барилгын ажлыг үргэлжлүүлнэ.	3,000.0 Нийслэл ийн төсөв	Барилгын угсралтын ажлын гүйцэтгэл, хувь	20	40	Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар Аддиктологийн төвийн хуучин барилгыг нурааж, шинээр барих ажлыг 2022-2025 онд нийт төсөвт өртөг нь 39.8 тэрбум төгрөгийг төсөвлөсөн. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтын дагуу Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/170 дугаар захирамжаар Аддиктологийн эмнэлгийн барилгын ажлыг эхлүүлэх эрхийг Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт шилжүүлсэн. Уг төндөрт "Бүрэн Одоод" ХХК нь шалгарч 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр тэрээ байгуулж, хуучин барилгын ажлыг нурааж буулгалтын ажил хийгдсэн. 2024 онд 3.0 тэрбум төгрөгийн төсөв батлагдсан. Төсвөөс шалтгаалан барилгын ажил 40 хувьтай үргэлжилж байна.	100
4.7	Гачуурт тосгоны Эрүүл мэндийн эмнэлгийн барилгын ажлыг үргэлжлүүлнэ.	2,661.2 Улсын төсөв	Барилгын угсралтын ажлын гүйцэтгэл, хувь	10	30	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Гачуурт тосгон Эрүүл мэндийн барилгын ажлыг 2022-2024 онд нийт төсөвт өртөг нь 3.0 тэрбум баталсан. /БЗД-ийн 20 дүгээр хороо, Гачуурт тосгон/. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын улсын байцаачийн 2012 оны 11 дүгээр сарын 23-ны 02-07-79/688, 2018 оны 05 дугаар сарын 10-ны 02-03-237/153 тоот дүгнэлтээр барилгын үйл ажиллагааг зогсоосон. Барилгын төндөрт "Ти Эм" ХХК 2.9 төгрөгөөр шалгарч, 2022 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс тэрээ байгуулж, хуучин барилгын ажлыг нурааж буулгалтын ажил хийгдсэн. 2023 онд төсөвт батлагдаагүй тул ажил түр зогссон. 2024 оны 2.6 тэрбум төгрөгийн төсөв батлагдсан. Барилгын ажил 95 хувьтай үргэлжилж байна.	100

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая төгрөгөөр)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилготой түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	8
4.8	Хан-Уул дүүрэгт нэгдсэн эмнэлгийн барилгын ажлыг эхлүүлнэ.	42,000.0 Гадаадын нээл, тусламж /АХБ/	Барилгын угсралтын ажлын гүйцэтгэл, хувь	-	30	Монгол Улсын Засгийн газар болон Азийн Хөгжлийн Банк хооронд байгуулсан 3843-MON, 3844-MON (SOL) гэрээний дагуу "Эмзэг бүлгийн хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр" төслийн хүрээнд Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр Хан-Уул дүүрэгт жишиг нэгдсэн эмнэлгийн барилга 30 хувийн гүйцэтгэлтэй, Чингэлтэй дүүргийн жишиг нэгдсэн эмнэлгийн барилга 2025 оны хатас жилээр баригдахаар төлөвлөгдөж байна.	100
4.9	Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилгын ажлыг үргэлжлүүлнэ. /Чингэлтэй дүүрэг/	4,000.0 Улсын төсөв	Барилгын угсралтын ажлын гүйцэтгэл, хувь	20	80	Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилгын гүйцэтгэлийг сонгон шалгаруулах ажиллагааг Төрийн худалдан авах ажиллагааны газар зохион байгуулж, гүйцэтгэгчээр "Солармед монгол" ХХК шалгарч 19.3 тэрбум төгрөгөөр гэрээ байгуулсан. Барилга нь 2024 оны 12-р сарын 30-нд ашиглалтанд орох байсан ч эмнэлгийн барилгын цахилгааны дэд өртөөг байгуулахад шаардлагатай газрын болон инженерийн шугам сүлжээний ажилтай холбоотойгоор 2025 оны 10 дугаар сард ашиглалтанд оруулахаар болж ЭМЯ гэрээг сунгасан. Барилгын ажлын явц 65 хувьтай байна.	81
4.10	Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн төвийн "Эрт илрүүлэг, оношилгооны төв"-ийн барилгын ажлыг үргэлжлүүлнэ.	2,702.8 Улсын төсөв	Барилгын угсралтын ажлын гүйцэтгэл, хувь	45	60	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээ Эрт илрүүлэг, оношилгооны төвийн барилгын ажлыг эхлүүлэхэд 2022-2024 онд нийт төсөв 5.5 тэрбум төгрөг байна. Эрт илрүүлэг, оношилгооны төвийн барилгын тендерийг Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар зохион байгуулж, гүйцэтгэгчээр "Монхауз" ХХК шалгарч, 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдөр гэрээ байгуулж, барилгын ажил 85 хувьтай үргэлжилж байна.	100

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая төгрөгөөр)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	8
4.11	Эрүүл мэндийн төвийн цогцолбор барилгын ажлыг үргэлжлүүлнэ. /Баянзүрх дүүрэг/	1,000.0 Нийслэл ийн төсөв	Барилгын угсралтын ажлын гүйцэтгэл, хувь	5	30	Баянзүрх дүүргийн 24 дүгээр хорооны нутаг дэвсгэрт баригдах төрийн байгууллагын газар эзэмших эрхийн 000015816 дугаартай гэрчилгээ 2021 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр Нийслэлийн Эрүүл мэндийн газарт 15 жилийн хугацаатайгаар 6994 м.кв-ыг эзэмшүүлэхээр гарсан. Газрыг бүрэн чөлөөлсөн. Барилга барих ажилд "Содон номин констракшн" ХХК шалгарч, Барилгажих талбайн хөрснөөс ус гарч, барилгын зураг өөрчлөгдөхөөр болсон. Ажлын гүйцэтгэл 20 хувьтай одоогоор барилгын ажил үргэлжлээгүй зогссон байна.	67
4.12	Нийслэлийн Түргэн тусламжийн бүрэн тоноглогдсон автомашинны хангалтыг нэмэгдүүлнэ.	1,020.0 Нийслэл ийн төсөв	Нийлүүлэх зориулалтын автомашин, тоо	-	50	Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/1510 дугаар захирамжаар эрх шилжин ирсэн нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2024 оны төсвийн жилд хэрэгжүүлэх "Эрүүл мэндийн байгууллагын түргэн тусламжийн авто машин (Улаанбаатар хот)" ажлын захиалагчийн хяналтыг хийсэн. Харьга эрүүл мэндийн байгууллагуудад 950.4 сая төгрөгийн 6 ширхэг эмнэлгийн зориулалттай автомашиныг хүлээлгэн өгсөн. Түргэн тусламжийн автомашинны хангалтыг 2024-2028 онд нэмэгдүүлнэ.	70
4.13	Ахмад настан эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах "Сонгинохайрхан" төслийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	100.0 Улсын төсөв	Нийлүүлэх, тоног төхөөрөмж, тоо	-	-	Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/237 дугаар захирамжаар Ахмад настанд үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах "Сонгинохайрхан" төслийн тоног төхөөрөмжийн эрхийг Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын тамгын газарт шилжүүлэн өөрчлөлт оруулсан.	-

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая төгрөгөөр)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	8
4.14	Эмнэлгийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 8 дугаар хороо/	350.0 Улсын төсөв	Нийлүүлэх, тоног төхөөрөмж, тоо	-	-	Тус төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтыг Баянзүрх дүүргийн худалдан авах ажиллагааны газар зохион байгуулж, Сүвэн-Уул ХХК шалгарч 329.8 төгрөгийн гэрээ байгуулагдсан. Гэрээний дагуу Баянзүрх дүүргийн эрүүл мэндийн төвд 27 нэр төрлийн 222 ширхэг тоног төхөөрөмж бүрэн нийлүүлэгдсэн.	100
4.15	Эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	800.0 Улсын төсөв	Нийлүүлэх, тоног төхөөрөмж, тоо	-	-	Тус төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтыг Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар зохион байгуулж, "Их шүүдэргэнэ Импорт" ХХК шалгарч 672 сая төгрөгийн гэрээ байгуулагдсан. Гүйцэтгэлээр гэрээний дагуу Сонгинохайрхан нэгдсэн эмнэлэгт 3 нэр төрлийн 32 ширхэг тоног төхөөрөмж нийлүүлэгдэнэ.	70
4.16	Дүүргийн эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	1,000.0 Улсын төсөв	Нийлүүлэх, тоног төхөөрөмж, тоо	-	-	Тус төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтыг Баянзүрх дүүргийн худалдан авах ажиллагааны газар зохион байгуулж, "Мед импекс интернэшнл" ХХК шалгарч 960.3 сая төгрөгийн гэрээ байгуулагдсан. Гэрээний дагуу Баянзүрх дүүргийн эрүүл мэндийн төвд 15 нэр төрлийн 116 ширхэг тоног төхөөрөмж бүрэн нийлүүлэгдсэн.	100
4.17	Эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 1, 2, 3, 7, 9, 10, 11, 12, 17, 19, 20, 21, 22, 23, 24, 27, 28, 29, 30, 32, 33, 34, 35, 37 дугаар хороо/	1,000.0 Улсын төсөв	Нийлүүлэх, тоног төхөөрөмж, тоо	-	-	Тус төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтыг Баянзүрх дүүргийн худалдан авах ажиллагааны газар зохион байгуулж, Биомед Трейд ХХК шалгарч 899.9 сая төгрөгийн гэрээ байгуулагдсан. Гэрээний дагуу Баянзүрх дүүргийн өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 34 нэр төрлийн 179 ширхэг тоног төхөөрөмж бүрэн нийлүүлэгдсэн.	100

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая төгрөгөөр)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилгот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	8
4.18	Өрхийн эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	500 Улсын төсөв	Нийлүүлэх, тоног төхөөрөмж, тоо	-	-	Тус төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтыг Баянзүрх дүүргийн худалдан авах ажиллагааны газар зохион байгуулж, "Ашид буян" ХХК шалгарч 475.2 сая төгрөгийн гэрээ байгуулагдсан. Гэрээний дагуу Баянзүрх дүүргийн өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 18 нэр төрлийн 70 ширхэг тоног төхөөрөмж бүрэн нийлүүлэгдсэн.	100
4.19	Өрхийн эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	97.5 Улсын төсөв	Нийлүүлэх, тоног төхөөрөмж, тоо	-	-	Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжих төсөл арга хэмжээ болох "Хан-Уул дүүргийн Өрхийн эрүүл мэндийн төвд шаардлагатай тоног төхөөрөмж"-ийг нийлүүлэхээр "Ай Ти Зон" ХХК шалгарсан. Энэ хүрээнд Хан-уул дүүргийн 1-21 дүгээр хорооны өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 40 ширхэг зөөврийн компьютерээр хангагдсан.	100
4.20	Өрхийн эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж, автомашин /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	1,500.0 Улсын төсөв	Нийлүүлэх, тоног төхөөрөмж, тоо	-	-	Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжих төсөл арга хэмжээ болох "Баянгол дүүргийн Өрхийн эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж, автомашин" нийлүүлэх ажлыг зохион байгуулан гүйцэтгэлийн хяналт тавин ажиглаж байна. Балц-1 Автомашин нийлүүлэхээр "Их төгс ялгуун" ХХК шалгарч, гэрээний дагуу 24 ширхэг автомашин нийлүүлэхээс 7 ширхэг автомашиныг Баянгол дүүргийн 3,9,10,11,13,20,21,22,23,26,29 дугаар хорооны 7 өрхийн эрүүл мэндийн төвд нийлүүлсэн. Балц-2: Компьютер, тоног төхөөрөмж нийлүүлэхээр "Би си ти" ХХК, шалгарч, 89.7 сая төгрөгийн гэрээ байгуулагдсан. Гэрээний дагуу Баянгол дүүргийн өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 45 ширхэг компьютер бүрэн нийлүүлэгдсэн. Балц-3: Эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлэхээр "Мед импекс интернэшлг" ХХК шалгарч, 693.6 сая төгрөгийн гэрээ байгуулсан. Гэрээний дагуу Баянгол дүүргийн өрхийн эрүүл	85

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая төгрөгөөр)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	8
						мэндийн төвүүдэд 4 нэр төрлийн 46 ширхэг тоног төхөөрөмж бүрэн нийлүүлэгдсэн.	
						Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжих төсөл арга хэмжээ болох "Сүхбаатар дүүргийн Өрхийн эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж" нийлүүлэх ажлын гүйцэтгэлд хяналт тавин ажиглаж байна.	
4.21	Өрхийн эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	1,000.0 Улсын төсөв	Нийлүүлэх, тоног төхөөрөмж, тоо	-	-	Багц-1: Эмнэлгийн тоног төхөөрөмжийг нийлүүлэхээр Баянгол Мед ХХК шалгарч 615.3 сая төгрөгийн гэрээ байгуулсан. Гэрээний дагуу Сүхбаатар дүүргийн 1-20 дугаар хорооны өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 7 нэр төрлийн 71 ширхэг тоног төхөөрөмж бүрэн нийлүүлэгдсэн. Багц-2: Автомашин худалдан авах ажиллагааг Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба тендэр шалгаруулалтыг зохион байгуулж байна. /Гүйцэтгэлээр 7 машин 7 автомашин Сүхбаатар дүүргийн өрхийн эрүүл мэндийн төвүүдэд нийлүүлэгдэнэ./ Багц-3: Компьютер тоног төхөөрөмжийг нийлүүлэхээр Ай ти зон ХХК шалгарч 96.6 сая төгрөгийн гэрээ байгуулсан. Гэрээний дагуу Сүхбаатар дүүргийн өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 32 ширхэг суурин компьютер бүрэн нийлүүлэгдсэн.	94
Зорилт 5. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт - Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд төр хувийн хэвшлийг түншлэлийг эрчимжүүлж, төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг цахимжуулах ажлыг сайжруулна.							

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая төгрөгөөр)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	8
5.1	Өрхийн эрүүл мэндийн төвтэй байгуулсан гурвалсан гэрээ байгуулж, хяналт тавина.	-	Гэрээ байгуулсан Өрхийн эрүүл мэндийн төв, тоо	144	149	Нийслэлийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн А/100 дугаар захирамжийн дагуу "Бүрэн хангалттай", "Хангалттай" үнэлгээтэй 146 Өрхийн эрүүл мэндийн төвтэй 2024 оны гүйцэтгэлийн гэрээг байгуулсан. Өрхийн эрүүл мэндийн төвийн 2024 оны гүйцэтгэлийн гэрээний хагас жилийн үнэлгээг нийт 146 өрхийн эрүүл мэндийн төвд хийж, нийслэлийн дундаж үнэлгээ 94.3%-тай үнэлэгдсэн. Нийслэлийн Засаг даргын 2024 оны захирамжийн дагуу шинээр байгуулагдсан 3 өрхийн эрүүл мэндийн төвтэй гүйцэтгэлийн гэрээг нэмэлтээр байгуулсан. Нийслэлд үйл ажиллагаа явуулж буй нийт 149 өрхийн эрүүл мэндийн төвийн гүйцэтгэлийн гэрээний жилийн эцсийн хэрэгжилтийг 2024 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн дотор үнэлж, үнэлгээний нэгтгэлийг ирүүлэх чиглэлийг 8 дүүргийн эрүүл мэндийн төвд 01/1859 тоот албан бичгээр хүргүүлэн ажилласан.	100
5.2	Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл нийслэлийн комиссын үйл ажиллагааг (тусгай зөвшөөрлийг шинээр олгох, үйл ажиллагааны чиглэл нэмэх, сунгах, түтгэлзүүлэх, хүчингүй болгох) цахимаар ил тод нээлттэй байршуулан авлига үүсэх эрсдэлээс сэргийлж ажиллана.	-	Тусгай зөвшөөрлийн комиссын хурал, тоо	11	12	Эрүүл мэндийн чиглэлээр тусгай зөвшөөрөл олгох Нийслэлийн комиссын хурлыг 2024 онд 11 удаа зохион байгуулж шинээр эмнэлэг-96, эмийн сан-189, чиглэл нэмсэн -32, чиглэл хассан-11, чиглэл өөрчилсөн эмнэлэг-1, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн эмнэлэг-9, эмийн сан-13, хүчингүй болгосон эмнэлэг-2, эмийн сан-2, чиглэл өөрчилсөн-1 шийдвэрүүдийг тус тус гаргасан байна. Нийт 282 тусгай зөвшөөрлийн гэрчилгээг шинээр олгож, ир health программд бүртгэж ажилласан байна. Тусгай зөвшөөрөлтэй болон тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаатай бүх 3000 гаруй аж ахуйн нэгжийн мэдээллийг license.mn сайтад нээлттэй байршуулсан.	100
			Орон тооны бус шинжээчийн	0	1	Орон тооны бус шинжээчийн сонгон шалгаруулалтыг 2024 оны I улиралд зохион байгуулан 85 иргэний материалыг хүлээн	100

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая төгрөгөөр)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	8
			сонгон шалгаруула лт, тоо			авч Тусгай зөвшөөрлийн комиссын хурлаар хэлэлцүүлэн шаардлага хангасан 43 иргэнийг шалгаруулсан.	
			Орон тооны бус шинжээчийг чадавхжуул ах сургалт зохион байгуулсан, тоо	0	2	Орон тооны бус шинжээчдийг чадавхжуулах, арга зүйн зөвлөгөө өгөх сургалтыг 2024 онд 2 удаа цахимаар зохион байгуулж 33 шинжээчийг хамруулсан.	100
5.3	Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхэд хууль, зүйн үндэслэлтэй нэг мөр эцэслэн шийдвэрлэх, хариуг албан ёсоор өгч хэвших, өргөдөл, гомдлын хугацаа, зөрчлийн үзүүлэлтийг бууруулах, шийдвэрлэлтийг сайжруулна.	-	Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа, хоног	10 хоног	9 хоног	Нийслэлийн Эрүүл мэндийн газрын "Өргөдөл, гомдол, санал, хүсэлт шийдвэрлэлтийн 2024 оны төлөвлөгөө", "Иргэдээс нийслэлийн нутгийн захирааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам"-ын хэрэгжилтийг хангаж, иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдол, хүсэлт саналыг тухай бүр www.egr.slaanbaatar.mn программд бүртгэж хуулийн хугацаанд шийдвэрлүүлэн ажиллаж байна. -Тайлант хугацаанд Нийслэлийн Эрүүл мэндийн газарт нийт 1749 өргөдөл, гомдол ирснээс 1675 буюу 96 хувийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэсэн. Хугацаа болгоогүй 74 өргөдөл, гомдол судлагдаж байна. Өргөдөл гомдлыг хэлтсээр нь ангилвал ЗТУХ-397, ЭМДХБӨХ-22, ЗТХ-557, ХШУДАХ-17, ЭМХХ-648, НЭАХӨХ-38, СХОХ-59 гомдол, хүсэлт ирсэн байна. Иргэн, аж ахуй нэгжээс ирүүлсэн өргөдөл гомдлыг шийдвэрлэхдээ 234 мессежээр, 1031 гомдолд утсаар хариу өгсөн, 153 иргэнтэй биеэр уулзаж хариу хүргүүлж, 257 гомдолд албан бичгээр хариу өгсөн. Иргэний талд шийдвэрлэсэн өргөдөл 1218, боломжгүй хариу өгсөн 433, бусад 21 тус тус шийдвэрлэсэн байна. Нийт өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 9 хоног 11 цаг 33 минут. -Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 03/464 албан бичиг, Нийслэлийн	100

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая төгрөгөөр)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	8
						Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/91 дүгээр захирамжаар иргэдийн өргөдөл гомдлыг бүрэн барагдуулж шийдвэрлэх, гомдол гаргахад нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлийн үнэлгээг сүүлийн 3 жилийн мэдээлэлд үндэслэн нарийвчлан гаргах чиглэлийн дагуу НЭМГ-ын даргын "Ажлын хэсэг байгуулах тухай" А/12 дугаар тушаал гаргасан. Энэ хүрээнд харьяа эрүүл мэндийн 28 байгууллага болон Эрүүл мэндийн газрын сүүлийн 3 жилийн өргөдөл гомдлын судалгааг гарган тогтоосон хугацаанд саналын хамт НЗДТГ-г хүргүүлсэн.	
	Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 19.1.3 дахь заалтад Эрүүл мэндийн байгууллага нь онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллага гэж заасан тул эрүүл мэндийн мэдээллийн аюулгүй байдал, мэдээллийн системийн өдөр тутмын үйл ажиллагааг явуулахад шаардлагатай сервер, тоног төхөөрөмжөөр байнгын хяналт тавьж ажиллана.	-	Дэмжлэгт хяналтад хамрагдсан байгууллагын тоо	18	5	Харьяа эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлэг болон өрхийн эрүүл мэндийн төвийн 182 байгууллагаас 36 байгууллагад дэмжлэгт хяналтыг хийгээд байна. Өндөр хурдны интернэт хэрэгцээг харьяа 9 дүүргийн эрүүл мэндийн төв, 4 нэгдсэн эмнэлгүүд 5тг- 100GB хүртэл шилэн кабелиар холбогдож байгаа бөгөөд үүнээс 4 тосгон, 13 алслагдсан өрхийн эрүүл мэндийн төв модем ашиглаж дотоод сүлжээний интернэтээр ханган ажиллаж байна.	100
5.4		-	Тоног төхөөрөмжийн тоо /сүлжээний галт хан төхөөрөмж/	-	6	-Кибер аюулгүй байдлын хүрээнд байгууллагын мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах сүлжээний "Галт хана" төхөөрөмжийг Хан-Уул дүүргийн эрүүл мэндийн төв, Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн төвд, Сүхбаатар дүүргийн эрүүл мэндийн төв, Баянзүрх дүүргийн эрүүл мэндийн төв, Баянзүрх нэгдсэн эмнэлэг, Нагайх дүүргийн эрүүл мэндийн төв гэсэн 6 байгууллагад Dell powerEdge R750xs R940xa 48 DDR4 DIMM slots, Supports RDIMM /LRDIMM, up to 2933MT/s, 6TB max. Server худалдан авалт хийж байгууллагын тасралтгүй үйл ажиллагааг ханган ажиллаж байна. -Харьяа эрүүл мэндийн байгууллагуудад мэдээллийн аюулгүй байдлын зөвлөх, аудитор ISMS, QMS, ABMS, Iesd auditor сургагч багшаас мэдээллийн аюулгүй байдлын сургалтыг хамтран зохион байгуулж нийт 15 байгууллагын мэдээлэл технологийн инженер, албаны дарга нарыг хамруулсан.	100

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая төгрөгөөр)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	8
5.5	Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг өөрийн харьяа эрүүл мэндийн байгууллагуудад үе шаттай хийлгэн гарсан дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.	-	Эрсдэлийн үнэлгээ хийлгэсэн байна.	-	2	-Кибер аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын алба, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам хамтран Кибер аюулгүй байдлын үндэсний тогтолцоог бэхжүүлэх, хуулийн хэрэгжилтийг хангахад тулгамдаж буй асуудал, шийдлийн талаар хэлэлцэх зэлжит "КИБЕР ТУСГААР ТОГТНОЛ" форумыг 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулсан сургалтад харьяа байгууллагын 14 мэдээллийн технологийн инженер, албаны дарга нарыг хамруулсан. СХДНЭ, БЗДНЭ, БЗДЭМТ, ЧДЭМТ, БЗНЭ, ХУДЭМТ гэсэн 6 байгууллагад Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг хийлгэхээр Тагнуулийн ерөнхий газарт албан бичиг илгээсэн боловч 2024 онд эрсдэлийн үнэлгээг хийх боломжгүй гэсэн хариу өгсөн. Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх зөвшөөрөл бүхий 32 хуулийн этгээд байдаг боловч харьяа байгууллагуудын 2024 оны төсөвт зардал тусгадаагүй тул санхүүжилт гаргах боломжгүй байна. Иймд "Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ"-г хийхэд шаардлагатай төсвийг харьяа эрүүл мэндийн байгууллагын төсөвт суулгахаар төлөвлөн ажиглаж байна.	90
	ХЭРЭГЖИЛТИЙН ДУНДАЖ ХУВЬ						95.6

ТАНИЛЦСАН:
ГАЗРЫН ДАРГА

ХЯНАСАН:
ЗАХИРГА, ТӨЛӨВЛӨЛТ, УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

НЭГЛТЭСЭН:
БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН АСУУДАЛ
ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



П.ЭРХЭМБУЛГАН

У.БАТ-ОЧИР

М.ОЮУН-ЭРДЭНЭ